

Р.Энхбат, Д.Баттогтох, Ч.Баттулга, А.Оюунтунгалаг,
Ц.Одонтуяа, Г.Ариунцэцэг, Б.Дэлгэрмаа, Ж.Хишигжаргал, Л.Орхонтуул,
Д.Одонтуяа, О.Наранчимэг, Ш.Пунсалдулам, Д.Долгорцэцэг,
Б.Гансайхан, Т.Нансалмаа, Б.Алтанмандах, Ц.Амарсанаа,
Б.Батцэцэг, Ж.Саранчимэг

МОНГОЛ ЁС, ХҮМҮҮЖИЛ

IV

Ерөнхий боловсролын сургуулийн
4 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2020 он

ННА 74.2
ДАА 373
М-692

Монгол ёс, хүмүүжил IV: Ерөнхий боловсролын сургуулийн 4 дүгээр ангийн сурах бичиг. /Энхбат Р., ба бусад; Ред. Пүрэв О. -УБ. 2019. -80х.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99978-61-97-9

Хүүхдүүд ээ!

Та бүхэн аав, ээжийнхээ захиснаар сайхан сэтгэл, саруул ухаан, эрүүл чийрэг бие, хийж бүтээх хүсэл тэмүүлэлтэй иргэн болон сурч, хүмүүжиж байна.

Хүүхэд бүр бодол, сэтгэл, үг, үйлдэл, дадал зуршил, хандлагаа зөв, буруу эсэхэд үргэлж анхаарч, бусадтай сайхан харилцан, өөрийнхөө болон бусдын сайн сайхны төлөө санаа тавьж, зөв шийдвэр гаргадаг, гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээж чаддаг болж төлөвшихөд энэхүү сурах бичиг тусална.

Энэ хичээлийн “Биеэ таньж, билиг авьяасаа хөгжүүлье” бүлгээр өөрийгөө, сэтгэлийн хөдөлгөөнөө таньж, өөрт буй сайн сайхан чанаруудаа нээн, улам хөгжүүлнэ. “Ачлах ариун ёс, хүндлэх хүний ёс” бүлгээр бусадтай чин сэтгэлээсээ эелдэг найрсаг харилцаж, эрдэнэт биеийг тань төрүүлж өсгөсөн аав, ээж, өвөө, эмээ болон эрдэм ном зааж сургасан багш, багшийн энтэй ачтануудаа хүндэлж баярлуулахын ач тус, арга ухаанд суралцана. “Уламжлалт аж төрөх ёс, зан үйл” бүлгээр үндэснийхээ уламжлалт ухаан, ёс заншлын учир утгыг ухаарч ойлгох, хүндэтгэн хэвшүүлэх, өвлөх хүсэл тэмүүлэлтэй болох юм.

Сурах бичгийн сэдэв бүрийг сэдэлжүүлэх дасгал, шинэ мэдлэг, ойлголт өгөх эх, сургамжит жишээ, тохиолдол, ёгт үлгэр, намтар, түүх, ёс заншлаа ойлгосноо бататгах дасгал, өөртөө тусган хэрэгжүүлэх, цаашид дадуулж хэвшүүлэх арга, харилцан ярилцах, харьцуулан бодож, эргэцүүлэх асуулт, даалгавартайгаар бичиж боловсрууллаа.

Сурах үйлсэд тань амжилт хүсье!

ТАНИХ ТЭМДЭГ



Анхааралтай
сонсоорой



Ажиглаарай



Ярилцаарай



Бичээрэй



Уншаарай



Яриарай



Тэмдэглээрэй



Харгалзуулаарай



Зураарай



Тоглоорой



Хосоор
ажиллаарай



Багаар
ажиллаарай



Гэрийн
даалгавар

ГАРЧИГ

I БҮЛЭГ. Биеэ таньж, билиг авьяасаа хөгжүүлье

1. Амрыг айлтгаж, мэндийг мэдэх ёс	8
2. Асуудлыг зөв танья	10
3. Асуудлыг хэрхэн шийдэх вэ?	12
4. Зөвөөр шийдэхийг эрмэлзье.	13
5. Эрдмийн ач	16
6. Хүсэл үү? Шунал уу?	18
7. Өгөөмөр сэтгэл	20
8. Сэтгэлийн тус	23
9. Нинжин сэтгэл	26
10. Бодлоо цэгнэе	28

II БҮЛЭГ. Ачлах ариун ёс, хүндлэх хүний ёс

1. Хариу нэхдэггүй ачтан	30
2. Аав, ээжийнхээ ачийг хариулъя	33
3. Ээждээ битгий тунирхаарай	38
4. Миний тус	39
5. Нутгийнхны хүндэтгэл, бахархал	41
6. Бусдыг баярлуулах үйл	43
7. Эвтэй бол мянгыг дийлнэ	47
8. Эв эе	49
9. Уучлах сэтгэл	52
10. Уучлалт хэрхэн гуйх вэ?	54
11. Сайн найз	55
12. Зөвийг дагая.	58

III БҮЛЭГ. Уламжлалт аж төрөх ёс, зан үйл

1. Монгол дээл	60
2. Сайхан шинэлж байна уу?	62
3. Цагаан сарын идээ	64
4. Цагаан идээ.	67
5. Хөхүүрийн айраг	69
6. Миний дуртай тараг	71
7. Монгол бөх	75
8. Аавын захиас	77
9. Бөхийн цол	78
Суралцсанаа дүгнэн цэгнэе	79

СУРГУУЛЬ





1. АМРЫГ АЙЛТГАЖ, МЭНДИЙГ МЭДЭХ ЁС



Сайн байна уу, найз аа?
Өчигдрийн явдалд намайг
уучлаарай!
- Сайн. Зүгээр дээ. Чи сайн уу?



Мэндлээрэй

Зэрэгцэж яваа хүмүүсээс
Зөвхөн нэгэнтэй нь мэндэлбэл
Зохисгүй муухай харагдана шүү
Зориуд санаж яваарай
Олон хүн дотроос
Онцолж нэгэнтэй нь мэндлээд
Орхиж заримыг нь үлдээвэл
Олиггүй муухай харагдана шүү
Маргаж найзыгаа гомдоосон бол
Маргааш нь заавал мэндлээрэй
Мартаж алдааг чинь уучлаад
Магад чамд баярлана шүү

ХҮМҮҮС



ЯАГААД МЭНДЭЛДЭГ ВЭ?

- Бие, сэтгэлийн амар мэндээ харилцан мэдэх гэж
- Бие биеэ хүндэтгэж
- Бусдад санаа тавьж
- Сайхан харилцаа эхлүүлэх, хадгалах гэж
- Ажил, үйлийг нь асууж, сонирхож
- Өөрийгөө танилцуулах гэж

Сайн
байна уу?



Сайн.
Сайн байна уу?

ЯАГААД МЭНДЭЛДЭГГҮЙ ВЭ?

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....



Туулын шийдвэр

Туулынх хотод нүүж ирээд удаагүй байв. Хот өндөр өндөр байшин, өнгө бүрийн машин, гоё сайхан бараатай дэлгүүр олонтой, олон хүнтэй, хүмүүс нь ихэвчлэн яаран явцгаах юм. Харин хөршүүд нь бие биеэ сайн танихгүй, хоорондоо ч мэндлэхгүй нь Туулд хачин санагдана. Хөдөө бол цөөн хүнтэй болоод ч тэр үү, нутаг усныхан маань бүгд л “Сайн байна уу, хичээл сурлага нь өндөр үү, аав ээжийнх нь ажил төрөл сайн уу?” гэнэ. Бие биедээ санаа тавьж, таарах болгондоо мэндлээд хэчнээн дотно байдаг билээ.

Нэг өдөр Туул аавтайгаа гэр лүүгээ орж яваад орцонд тааралдсан ахтай “Сайн байна уу, ах аа?” гэж чангаар мэндлэв. Тэр ах гайхаж харснаа инээмсэглэн: “Сайн, сайн. Танайх энд нүүж ирсэн айл уу?” гэж асуулаа. Аав “Тийм ээ, бид саяхан Хөвсгөлөөс нүүж ирлээ” гээд яриа өрнүүлэв.

Туул тэднийг танилцуулсандаа баярлаж, “Байрны маань бүх хүн хоорондоо ингэж мэндэлдэг бол мөн ч сайхан даа” хэмээн бодлоо. Тэгээд энэ бодол санаагаа биелүүлэх төлөвлөгөө зохиож, маргаашаас эхэлж хэрэгжүүлэхээр шийджээ.



Асуултын дагуу ярилцана уу.

- Туул ямар шийдвэр гаргасан бэ?
- Туул яагаад энэ шийдвэрийг гаргах болсон бэ?
- Туулын төлөвлөгөө хэрэгжих болов уу?



Ажиглаад, суралцаарай! Дараах хүснэгтийг гүйцээж бичнэ үү.

Хэн, хэнтэй мэндэлж байна вэ?	Мэндчилгээний ямар үг хэрэглэж байна вэ?	Яаж мэндэлж байна вэ?	Юу сурах вэ?
Зурагтын нэвтрүүлэгч үзэгчтэй			
Багш сурагчидтай			
Нутгийн хүмүүс бие биетэйгээ			
Найзууд утсаар ярихдаа			

2. АСУУДЛЫГ ЗӨВ ТАНЬЯ



Зурагт юуг дүрсэлсэн байна вэ?



Асуудал юунаас үүссэн бол? Зургуудаас нэгийг сонгож, бяцхан түүх зохион бичээрэй.



Зохиосон эхээ ангийнхандаа уншиж танилцуулаарай.



Асуултын хариуг гүйцээн нөхөж бичнэ үү.



Ганаагийн муу зуршил

Ганаа сэргэлэн цовоо, эрүүл чийрэг хүү боловч гар утаснаас салдаггүй муу зуршилтай. Ээж нь эмнэлэгт ээлжийн сувилагч, харин аав нь холын тээвэрт явж, олон хоногоор гэрийн бараа харахгүй. Тэд хүүгээ хаана, юу хийж байгааг асууж, холбоо барих, тоогоо бодох, үгээ цээжлэхэд нь хэрэгтэй гээд хүссэн гар утсыг нь авч өгчээ. Гэтэл утастай болсноос хойш Ганаа хоолоо идэх, зурагт үзэх, босож суух, ер нь юу ч хийж, хаашаа ч явсан утаснаасаа салахаа больжээ. Аав, ээж нь олон дахин хэлж, зэмлэн утсыг нь нууж, хураагаад ч нэмэргүй байлаа. Тэр найзуудтайгаа тоглохоос илүү, өдөржин гэртээ утсаараа оролдох тул найзууд нь цөөрч, ааш зан нь эвдрэн, уцаартай, залхуу болж, хичээл сурлага нь муудаад эхэлжээ. Харин багш нь түүнд тусалж, асуудлыг нь хамтран шийдэх төлөвлөгөө гаргажээ.



Эхийг дараах асуултуудын дагуу шинжилж, хариултыг бичээрэй.

Асуудал хэнд, юунд байна вэ?	Ямар асуудал байна вэ?	Ямар хувилбараар шийдэж болох вэ?	
		Сайн тал	Муу тал
Гар утсанд			
Ганаад			
Аав, ээжид			



Ганаад асуудлаа шийдвэрлэхэд нь хэн, хэрхэн тусалж болох вэ?

3. АСУУДЛЫГ ХЭРХЭН ШИЙДЭХ ВЭ?



Зураглалыг ажиглаад, ярилцаарай.



Шанага будаа


Нэгэн хүү хараа муутай ээжийнхээ хамт гуйлга гуйн амьдардаг байжээ. Ядуугийн зовлонгоос хэрхэн гарч болохыг хүү байнга эргэцүүлнэ. Ингээд нэгэн өдөр эрдэм мэдлэгтэй, ажилсаг хичээнгүй хүмүүс л сайхан амьдарч байгааг ухаарч, байсан бүх мөнгөө шавхаж аваад зах гарлаа. Түүний мөнгө ганц шанага будаа л авч хүрэлцэв.

Хүү будаагаа авч, гэртээ хариад тээрэмдтэл гурван шанага гурил болжээ. Маргааш нь хүү зах дээр очиж, гурилаа зарлаа. Олсон мөнгөө гурван тэнцүү хувааж, эхний хэсгээр нь дахин шанага будаа авав. Нөгөө хэсгээр нь гэртээ хүнс авч, үлдсэнийг нь сурахад зориулан хадгаллаа. Өдөр бүр ийнхүү хураасаар хүү сургуульд сурах мөнгөө хуримтлуулжээ.

Хүүг сургуульд сурах болсныг мэдсэн хүмүүс түүнд баяр хүргээд, ээжийг нь харж хандахаа амлалаа. Ингээд ээж нь зах дээр сууж тээрэмдсэн гурилаа дэргэдээ тавьж зарах болов. Хүүгийн хичээл зүтгэлийг үнэлсэн хүмүүс гурилыг дуртайяа авцгаана. Хүү орой ирж, ээжийгээ үүрэн, шанага будаагаа аваад харих болов. Цаг хугацаа өнгөрсөөр, хүү ч эрийн цээнд хүрч, эрдэм мэдлэг, нинжин сэтгэлтэй хүн болон, ээжийнхээ хамт амар сайхан жаргасан гэдэг.



Дараах асуултын дагуу эргэцүүлэн бодоод, хариулж бичээрэй.



Өөрт тохиолддог асуудлаас сонгон, дараах 5 алхмаар шийдэж туршаарай.

1. Асуудлыг олж таниарай (Асуудал юунд байна вэ?)
2. Шийдэх ямар арга замууд байгааг олоорой.
3. Хамгийн сайн аргыг сонгоорой.
4. Сонгосон аргаа хэрэгжүүлж туршаарай.
5. Ямар үр дүнтэй байгааг үнэлээрэй.



Асуудлаа бие даан шийдэж чадахгүй бол бусдаас тусламж, дэмжлэг хүсээрэй. Аав, ээж, өвөө, эмээ, багш, найз нар чинь гээд чамд тусалж чадах олон хүн бий.

4. ЗӨВӨӨР ШИЙДЭХИЙГ ЭРМЭЛЗЬЕ



Нэгэн ангийн хүүхдүүд ангид болон сургуульд үүсдэг асуудлуудыг жагсаан бичиж шийдэх арга замыг олжээ. Чи ч бас өөртөө тулгарсан асуудлыг шийдэх арга замыг олоорой.

№	Манай ангид тулгарч буй асуудлууд
1	Ангийн хүүхдүүд өөрийн эд зүйлээ хаядаг.
2	Хөвгүүд заримдаа охидыг уйлуулдаг.
3	Багш нараас өөр хүмүүстэй мэндэлдэггүй.



Асуудлаа хамтарч шийдье.

Ямар асуудал байна вэ?	Сурагчид багш нараас өөр хүмүүстэй мэндэлдэггүй
Юунаас болсон гэж үзэж байна вэ?	Ичдэг учраас Яаж мэндлэхээ мэддэггүй учраас Санамсаргүйгээс мэндлэхгүй өнгөрдөг Сайн танихгүй учраас Завгүй байдаг болохоор нь Хүсдэггүй учраас
Юу хийх вэ? Яах вэ?	Үйлчлэгч эгчтэй Өөр хичээлийн багш нартай Жижүүр ах, эгчтэй Сургуулийн эмчтэй Захиралтай Сургалтын менежертэй Найз нартайгаа мэндэлж байна.
Оновчтойг сонгоё.	Шийдэл: - Хүн бүхэнтэй мэндэлж сурцгаая. Үйлчлэгч эгчтэйгээ - Бидний ангийг цэвэр байлгадаг гэж талархан хүндэлж мэндэлье. Хүн бүхнийг хүндэтгэн мэндэлье. Тэд бүгд эрх тэгш, ач тустай хүмүүс.

Хөрш айлын хүүхдүүд



Хөрш айлын хоёр хүү сайхан найзалдаг байлаа. Тэд зав л гарвал хамт тоглоно. Нэгэн өдөр хамтдаа гол руу явахаар болов. Замдаа элдвийг ярилцан алхсаар голын эрэг дээр очоод усаар байлдаж, чулуугаар тоглон, эрвээхэй барьж, хөгжилдөж болох бүх л зүйлийг хийв. Тэгээд сүүлд нь эрэг дээр хэвтэх ундааны шилийг чулуугаар шидэж хагалахаар боллоо. Жижиг чулуугаар онохгүй байсан тул том чулуугаар шидэцгээв. Эцэст нь, чулуунд оногдсон шил тасхийтэл хагарлаа. Миний чулуу оносон. Үгүй, минийх оносон гэж маргалдсаар тэд тоглоомоо өөрчлөв. Удалгүй жаахан охины уйлах дуу сонсогдлоо. Хоёр найз тэр зүг яаран гүйж очтол охин тэдний хагалсан шилэнд хөлөө зүсчихжээ. Тэд яахаа мэдэхгүй хэсэг зогслоо. Гэтэл нэг нь зугтан гүйв. Үлдсэн найз нь яасан бол?



Дээрх тохиолдолд асуудал нь юу байсан бэ?

.....



Хүүд асуудлаа шийдэхэд нь туслаарай. Тохирох хариултыг тэмдэглэж, өөрийн санааг нөхөж бичээрэй.

- Охиноос уучлалт гуйна.
- Охинд тусалж, хөлийг нь бооно.
- Голын эрэг дээрх хогийг цэвэрлэнэ.
-



Чи асуудалд хэрхэн ханддаг вэ? Энэ талаар өөрийгөө шинжээрэй.

	Асуудалд хандах хандлага	Тийм	Үгүй	Заримдаа
1	Надад өдөр бүр асуудал тулгардаг.			
2	Би асуудалд тайван ханддаг.			
3	Би асуудлыг цаг алдалгүй шийддэг.			
4	Би асуудал юунд оршиж байгаа учир шалтгааныг олж чаддаг.			
5	Би асуудлыг хэрхэн шийдэхээ төлөвлөдөг.			
6	Би асуудалд бусдыг буруутгалгүй, асуудлыг өөрөөсөө хайж чаддаг.			
7	Би асуудал тулгарвал өөрт тусалж чадах хүмүүст ханддаг.			
8	Би асуудлыг шийдэхдээ аав, ээж, багш, ахмад хүний зөвлөгөөг авч, хамтран шийддэг.			
9	Би бие даан шийдвэр гаргасан ч хэрэгжүүлэхээсээ өмнө аав, ээж, багш, ахмад хүнээс зөвлөгөө авдаг.			
10	Би асуудлаа шийдэж чаддаг.			
11	Би өөрийн гаргасан алдааг дахин гаргахгүйг хичээдэг.			
12	Би асуудлын тухай эхлээд боддог.			
13	Би асуудлыг шийдэхээсээ өмнө уурладаг.			
14	Би асуудлыг шийдэхдээ төлөвлөдөг.			




Хүн бүрд асуудал бэрхшээл байнга тулгардаг. Харин бурууг бусдаас хайлгүй, асуудалд ухаалаг, тайван хандах нь чухал. Асуудлаа бие даан шийдэх нь хэдий сайн ч зөв, оновчтой шийдвэр гаргах нь хамгаас чухал. Тиймээс аливаа асуудлыг шийдэхэд чинь туслах амьдралын арвин туршлагатай, чамд чин сэтгэлээсээ туслах олон хүн байгааг битгий мартаарай.

5. ЭРДМИЙН АЧ



Бага, дунд насандаа эрдэм сурах болон өтөлтлөө эс сурахыг юутай зүйрлэж байна вэ? Дараах үгс болон зургуудыг зөв харгалзуулж холбоод, утгыг тайлбарлан ярилцаарай.

Бага насандаа эрдэм сурвал



түнэр харанхуй мэт

Дунд насандаа эрдэм сурвал



үдийн нар мэт

Өтөлтлөө эрдэм эс сурвал



өглөөний нар мэт



Ном эрдэм сурахын ач тус юу вэ?



Номын хүч

Бяцхан хүү хөдөө нутгаасаа хотод шилжин суралцах болов. Ээж нь түүний нулимстай нүдийг арчаад “Миний хүү ээжийгээ санах, эсвэл хүнд хэцүү үе тохиолдвол үүгээр ном авч уншиж байгаарай. Тэр ном дотор чинь ээж нь байгаа шүү” гээд цөөхөн мөнгө өгчээ. Хүү ээжийгээ санах болгондоо тэр мөнгөнөөсөө ном худалдан авч уншдаг байв. Үнэхээр ч уншсан ном дотор ээж нь амьдарч, түүнд туслах мэт санагддаг байлаа.

Харин одоо тэр алдартай зохиолч болжээ. Түүний бичсэн олон сайхан номыг мянга мянган хүн амтархан уншдаг. Хүн төрөлхтний гайхамшиг болсон “Ном”-ын хүч ийнхүү илэрч, хүмүүст зөв хүмүүжиж, зөв амьдрах замыг заадгийн нэгэн тод жишээ энэ билээ.



Асуултын дагуу ярилцаарай.

- Ээжийгээ санан ном уншдаг байсан нь хүүг юунд хүргэсэн бэ?
- Эрдэм ном сурч, сайн сайхан яваа ойр дотнын хүмүүсийнхээ жишээг ангийнхантайгаа ярилцаарай.



Амжилттай суралцахад юу чухлыг ярилцан, өөрийнхөө санааг нэмж бичнэ үү.

Залхуурахгүй байх

Өдрийн ажлаа төлөвлөх

Цагийн юмыг цагт нь хийх

Зорилгоо тодорхойлох

.....


.....

.....

.....



Өдрийн ажлаа зураглан бичээрэй. Чи өдөрт хэдэн төрлийн ажил хийдэг вэ?



Чи цагаа хэр зөв хуваарилдаг вэ? Хүснэгтийг нөхөж бичнэ үү.

Цагийн хуваарь	Хийх зүйл	Биелэлт
Өглөөний 07.00-07.30		

6. ХҮСЭЛ ҮҮ? ШУНАЛ УУ?



Хүсэл үү, шунал уу? Ярилцаад, ялгаарай.

Ээж ээ, би үүнийг авмаар байна. Ганаад ийм гар утас байгаа, ёстой гоё.

Гутал маань ханзарчихлаа. Шинэ гутал авхуулах юм сан.

Аав аа, би машинаар хүргүүлмээр байна. Манай ангийнхан таны шинэ машиныг хараг.

Өнгөрсөн сард авхуулсан номоо уншаад дуусчихсан. Шинээр гарсан сонирхолтой номыг авхуулмаар л байх юм.



Шүлгийг анхааралтай уншаарай.

Дугуйтай болох хүсэл

Дугуйтай болох хүслээ
 Дуулгаж аавдаа хэллээ.
 Орлого мөнгө дутмаг байна гэж
 Онцолж аав маань учирлалаа.
 Хичээл номдоо одооноос шамдаад
 Хэрэв дүнгээ сайжруулж чадвал
 Сар бүр хуримтлал үүсгээд
 Сайхан дугуй авч өгье гэлээ.
 Хүсэл, шуналаа ялгах ухаан
 Хүн бүрд туйлаас хэрэгтэй.
 Аавыгаа ерөнд оруулан байж
 Авсан дугуй надад хэрэггүй.
 Бусдыг хохироогоод ч хамаагүй
 Буруу аргаар зорьсондоо хүрвэл
 Энэ бол “Шунал” гэж
 Ээж надад хэлсэн юм.
 Хичээл номдоо сайтар шамдан
 Хуримтлуулсан мөнгөөрөө дугуй
 авбал
 Хэнийг ч би зовоогоогүй учраас
 Харин энэ нь “Хүсэл” болно.





Асуултад хариулж бичээрэй.

- Хүү хүслээ “Шунал, хүсэл”-ийн аль нь болохыг хэрхэн таньж, яаж шийдсэн бэ?
- Шүлэгт хүсэл, шунал хоёрын ялгааг юу гэж тодорхойлсон байна вэ?

Дугуйтай болох	
Хүсэл	Шунал



Дараах жишээнүүдийг уншаад, хүсэл гэж үзсэн жишээг ✓ тэмдгээр тэмдэглээрэй.



Дараа нь багаар хэлэлцэж, хүсэл, шунал аль нь болохыг зөв ялгаарай.

Гиймаа олон гоё даашинзтай. Ээж нь түүнд саяхан бас нэг урт даашинз авч өгсөн. Гэтэл тэр шинэ жилээр дахиад өөрийг авхуулна гэж шалав.

Олмаад эгч нь үлгэрийн ном авч өгчээ. Олмаа номоо уншиж дуусаад дахиад үлгэрийн гоё ном уншихыг хүсэж, эгчээсээ өөр ном авч өгөөч гэж гуйлаа.

Охин ээжтэйгээ дэлгүүрт явж байтал зурагтаар сурталчилж байсан хүүхэлдэй нь хямдарсан байв. Тэр ээжийгээ гуйсаар өөрт нь цүнх авах гэж байсан мөнгөөр хүүхэлдэйг авхуулав.

Тэргэл гурван үзгэн балтай боловч хоёр нь дуусаж байгаа. Нэг нь сайн гардаггүй юм. Тэр ээжээсээ сайн гардаг үзгэн бал авч өгөхийг гуйлаа.

Хүү тоглож байгаад гутлаа урчихжээ. Түүнд өөр өмсчихөөр гутал байхгүй учир ааваасаа гутал авч өгөхийг гуйв.



Шунаж байгаагаа мэдвэл хэрхэх вэ?


Манай өвөг дээдэс шуналын хор уршгийг сайтар ухаарч, ихэд жигшин, цээрлэдэг байжээ. Шуналаас атаархах, худал хэлэх, хулгай дээрэм хийх, амьтны амь таслах зэрэг бүх муу үйл, муу сэтгэл урган гардаг. Тиймээс бусдын эд зүйлд шунах, атаархах сэтгэлийг хорьж, тэвчиж сурах нь сайн үйлийн нэг юм.



Шуналтай хүн өөрийгөө болон бусдыг хэрхэн хохироодог талаар ярилцаарай.




Чи хүслээ шинжээд, даалгаврыг гүйцэтгээрэй. Жингийн туухай дээр чиний авах, өгөх хүслийг дэнсэлж үзье гэвэл аль нь их байх бол?



7. ӨГӨӨМӨР СЭТГЭЛ



Чи ямар бэлгэнд дуртай вэ? Сонгож дугуйлаарай. Өөр сонголт байвал нэмж дэвтэртээ зураарай.



Чи хүмүүст ямар бэлэг өгөх дуртай вэ?



Өгөөмөр сэтгэлийн бэлэг

Санжаагийн төрсөн өдөр болоход долоо хоногийн хугацаа үлдсэн байлаа. Өмнөх төрсөн өдрөөр авхуулсан нисдэг тэргээрээ хоёр хоног тоглоод л сэнс нь хугарсан тул сагсанд овоолсон эвдэрхий тоглоомууд руу шидэж орхисон. Харин энэ жилийн төрсөн өдрөөрөө илүү гоё зүйл авхуулна гэж бодсон тул зурагтын зар сурталчилгааг их л анхааралтай үзнэ. Тэр машин, робот, нисдэг тэрэг, буу гээд хэдэн арван тоглоом авхуулсан ч дахиад шинийг, өөр гоёыг хүснэ. Сурсан зангаараа хаана ямар шинэ тоглоом, сонирхолтой зүйл гарч вэ гэдгийг мэдэхээр суваг солин, зурагтаа үзэж суув.

Гэтэл нэгэн бяцхан хүү хүндээр өвдөж, эмчилгээний төлбөрөө төлж чадахгүйгээс маш хэцүү байгаа тухай ээж нь уйлан ярьж, тусламж гуйхыг харжээ. Хүү түүнийг өрөвдөж, цуглуулсан мөнгөө бэлэг авхуулахын оронд хүүгийн эмчилгээнд зориулахаар шийджээ. Аав ээж нь ч хүүгийнхээ шийдвэрийг зөвшөөрч, эмнэлэг рүү явцгаалаа.

Тэднийг очиход царай нь цонхийж, ядарсан бяцхан хүү орон дээрээ хэвтээд янз бүрийн тоглоом, машин, онгоцыг нямбайлан зурж байв. Түүний зургууд Санжаагийн эвдсэн тоглоомуудтай адилхан харагджээ. “Чи ямар гоё зурдаг юм бэ?” гэтэл хүү “Би удахгүй эдгэрээд ийм тоглоомуудтай болохыг мөрөөддөг” гэлээ. Санжаа авчирсан мөнгөө хүүд өгч, “Заавал хурдан эдгээрэй” хэмээн хэлэхдээ сэтгэл нь хөдөлж, жаргалтай байлаа.



Асуултын дагуу ярилцаарай.

- Санжаагийн тоглоом авах хүслийг өөрчлөхөд юу нөлөөлсөн бэ?
- Тэр яагаад хүүд туслахаар шийдсэн бэ?
- Чи төрсөн өдрөөрөө хэн нэгэнд туслах сайн үйл хийж үзсэн үү?





Нөхөж бичээрэй.

Шунаж, хүсдэг хүний бодол:

Дахиад шинэ загвар гарсан болов уу?

.....

.....

.....

.....

.....

.....

Өгөхийг хүсдэг хүний бодол:

Дахиад бусдыг баярлуулах юм сан.

.....

.....

.....

.....

.....

Хэн нь илүү аз жаргалтай байх бол? Яагаад?



Шунах болон өгөөмөр сэтгэлийн үр дагавар юу вэ? Ялгааг харьцуулан бичээрэй.



Шунах, хомхойрох сэтгэл



Өгөөмөр, өглөгч сэтгэл



Чи дараах үйлээс алийг нь хэрэгжүүлдгээ тохирох нүдэнд тэмдэглээрэй.

Нөхцөл	Үгүй	Хааяа	Байнга
Найзуудаасаа “Би яаж туслах вэ?” гэж асуудаг.			
Тусламж гуйхыг нь хүлээхгүй, өөрөө санаачлан тусалдаг.			
Хэн нэгнийг сэтгэлээр унасан үед аргадаж тайтгаруулдаг.			
Амттанаа бусдаас харамлахгүй хуваалцдаг.			
Хүмүүс миний тоглоом, эд зүйлээс гуйвал харамлахгүй өгдөг.			



Дээрх хүснэгтэд “Үгүй, Хааяа” гэж хариулсан үйлүүдээ байнга хийдэг болж хэвшээрэй. Тэгээд зан үйлдээ гарсан өөрчлөлтөө ажиглаарай.

8. СЭТГЭЛИЙН ТУС



Зургийг ажиглаарай. Чамд ямар сэтгэгдэл төрж байна вэ?





Сэтгэлийн хүч

Нэгэн хүн цасан шуурганаар төөрчээ. Тэр маш их даарч, хүч тамир нь барагдаад, цааш явж чадахаа болив. Хөдөлж ч чадахгүй хэвтэж байтал шуурганы исгэрэх чимээтэй хамт хүүхэд уйлах дуу сонсогджээ. Эцсийн хүчээ шавхаад мөлхөн очвол нэгэн бяцхан хүү дагжин чичрээд уйлж байв.

Бяцхан хүүг өрөвдөн хайрлах сэтгэл нь түүнд хүч өгч, бүх биеэр нь дулаан илч гүйх мэт болов. Тэгээд хүүг биедээ наан тэврээд босож алхлаа. Хаанаас ийм их хүч гарсныг бүү мэд. Шуурга хүртэл тэдэнд туслах гэсэн мэт намдаж, орчны зүйл харагдаж эхлэв. Удалгүй хот айл харагдлаа. Хацрыг нь даган баярын нулимс бөмбөрч “Айл, хүмүүс” гэж амандаа шивнэсээр гүйв. Ийнхүү хүүг хайрласан сэтгэлийн хүчээр тэд хоёулаа аврагджээ.



Асуултын дагуу ярилцаарай.

- Хэрэв энэ хүн зөвхөн амиа боддог байсан бол юу болох байсан бэ?
- Чи ийм тусч, нинжин сэтгэлтэй хүний тухай сонсож, бас таарч байсан уу? Ангийнхандаа ярьж өгөөрэй.



Чамд ямар үед энэрэх, туслах сэтгэл төрдөг вэ? Жишээг уншаад, өөрийнхөө бодлыг нэмж бичээрэй.

Аав, ээжийгээ ажлаасаа ядраад ирэхийг харахаар	Бяцхан хүүхэд уйлж байхыг харахаар		

Хичээлд явах замд



Хичээлд явах замд
Хашаагүй бор гэр бий.
Хэдэн ч настай юм бэ
Намхан буурал эмээ бий.
Нансал эмээгийн дорвол
Чихэр ёотон өгнө.
Насаараа хүлээж суугаа
Хүүгийнхээ зургийг үзүүлнэ.
“Эвий, сайхан хүү минь
Ирнэ дээ” гэхдээ уйлна.
Сайн хүн болоорой гээд
Саравчилж биднийг үднэ.
Хичээл тараад харихдаа
Эмээгийн дорвол бид очно.
Хэд гурваараа нийлээд
Модыг нь хөрөөдөж өгнө.



Охид гэрийг нь цэвэрлээд
Ор дэрийг нь цэмбийлгэнэ.
Хөвгүүд түлээ хагалаад
Хөх саванд нь ус дүүргэнэ.
Ээ хөөрхий... хөөрхийс минь... гэж
Эмээ минь бидэнд үнэнээсээ баярлана.
Хүү нь хурдан ирээсэй... ирээсэй... гэж
Хүүхдүүд бид чин сэтгэлээсээ хүснэ.



О.Сундуй



Шүлгээс тохирох хэсгийг олж харгалзуулан бичээрэй.

Энэрэх сэтгэл

Туслах сэтгэл

Юу хэрэгтэйг
нь мэдэхЧадах зүйлээ
хийж өгөх

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....

.....
.....
.....



Өөрийн бодол, үйлдлийг нөхөж бичээрэй.

- Тоглоомын талбайд тоглож байхад чинь бяцхан хүүхэд хэн нэгнийг хайгаад уйлж байвал
- Хамт тоглож байсан найз чинь шургаж унан өвдгөө шалбалчихвал
- Ойд эхээсээ төөрсөн янзагатай таарвал

9. НИНЖИН СЭТГЭЛ



Зургийг хараад, эхэд юуны тухай өгүүлэхийг таамаглаарай.



Найзууд

Ганхүү үдийн цайнд орохоор ангийнхантайгаа явж байснаа гэнэт мөнгөгүй гэдгээ санах. Өглөө ээжээсээ хоолны мөнгө авахыг хүссэн ч ээж нь цалин буугаагүй болохоор хүүдээ мөнгө өгч чадахгүй нь гэсэн байжээ. Мөнгөгүй ирснээ хэлэхээс санаа зовоод “Би өлсөөгүй, юм идмээргүй байна” гэж хэлэх зуур ходоод нь хоржигнон дуугарав. Найзууд нь түүн рүү гайхан харснаа “Чи түрүүхэн хоол идье гэж хэлсэн биз дээ” хэмээхэд нь юу хэлэхээ мэдэхгүй түгдрэв. Гэтэл ангийнх нь Төгсөө “Хамт явъя, чи урьд нь надад хоол авч өгсөн. Одоо миний ээлж. Чи юу идмээр байна?” гэв. Ганхүү гайхан “Би Төгсөөд хоол авч өгөөгүй шүү дээ” гэж бодсоор түүнийг даган алхав. Цайны газар хүүхдүүд хоолоо захиалан авч, ширээнд сууцгаалаа. Төгсөө Ганхүүд өөрийнхтэйгөө адил хоол авч өгөв. Ганхүү нэрэлхэн идэж чадахгүй сууж

байтал Төгсөө “Сайхан хооллоорой” гээд инээмсэглэв. Хооллож дуусаад гарсны дараа Ганхүү Төгсөөгөөс “Чи яагаад тэгж хэлсэн юм бэ?” хэмээн асуутал “Найз нь чамайг ойлгоно шүү дээ. Орой тартал өлсөж болохгүй, зүгээр дээ” гээд мөрийг нь алгадав.



Асуултын дагуу ярилцаарай.

- Төгсөө яагаад Ганхүүд тусалсан бэ?
- Ганхүү ангийнхандаа яагаад үнэнээ хэлээгүй вэ?
- Чиний найзад ийм зүйл тохиолдвол чи яах байсан бэ?



Чи дараах тохиолдолд яах вэ? Нөхөж бичээрэй.

Шатаар гарах гээд чадахгүй байгаа настай хүнтэй тааралдвал	Юу гэж бодох вэ?
	Юу гэж хэлэх вэ?
	Юу хийх вэ?
Төөрсөн хүүхэдтэй тааралдвал	Юу гэж бодох вэ?
	Юу гэж хэлэх вэ?
	Юу хийх вэ?
Ангийн чинь хүүхэд өвдөөд эмнэлэгт хэвтвэл	Юу гэж бодох вэ?
	Юу гэж хэлэх вэ?
	Юу хийх вэ?
Гэрийн чинь гадаа бяцхан гөлөг гийнаж байвал	Юу гэж бодох вэ?
	Юу гэж хэлэх вэ?
	Юу хийх вэ?

10. БОДЛОО ЦЭГНЭЭ



Уншаад ярилцаарай.

Аливаа зүйлийг хүн бүр өөр өөрөөр хүлээж авдаг. Жишээ нь: Цэвэр агаарт зугаалах гэтэл гэнэт бороо орчихлоо гэж бодъё. Үүнийг “Бороо орох сайхан шүү. Өвс ногоо ч сэргэнэ. Борооны дараах цэвэр агаарт л алхъя” гэж таашаах хүн бий. Харин сөргөөр харах нэгэн “Яасан зогсдоггүй усан бороо вэ? Салхинд ч гарч чадахгүй юм” хэмээн уцаарлана.



Аливааг эерэг болон сөргөөр бодохын ялгаа юу байх вэ?



Нисгэгч өвгөдийн бодол

Насаараа онгоцны нисгэгч байсан хоёр өвгөн хууч хөөрч суув. Нэгийнх нь царай нэлээд үрчлээтэж, нүд нь гунигтай, чих нь хатуу болжээ. Тэрээр “Миний энэ хоёр чих юу ч сонсохоо байжээ. Насаараа онгоцны нүргэлсэн чимээ сонсож, нойр, хоолгүй ажилласны уршиг энэ дээ” гэж уцаарлангуй хэлэв.

Харин нөгөө нисгэгч өтөлж, үрчлээ суусан ч царай нь гэрэлтэнэ. Тэрээр “Бид ч уудам тэнгэрт дүүлэн нисэж, хөх тэнгэрийн эзэн болж явсан азтай хүмүүс. Мөнгөн цагаан хөлгийн жолоог зална гэдэг сайхан даа. Миний чих гайгүй сонсоод л байх юм” гээд инээмсэглэн суув.




Хоёр нисгэгчийн бодлын ялгаа юу вэ?

	Эхэлж ярьсан нисгэгч	Дараа нь ярьсан нисгэгч
Бодол санаа		
Дүгнэлт		



Аав, ээж, гэрийнхнээ “Хичээлээ хий” гэхэд төрдөг бодлоо ангилж бичээрэй.

Эерэг бодол: 

.....

.....

.....

.....

.....

.....

Сөрөг бодол: 

.....

.....

.....

.....

.....

.....




Сөрөг бодлоо шинжиж, эерэг болгон бичээрэй.

.....



Аливаад эергээр хандахын ач тус юу вэ?




Бухимдаж хийсэн аливаа ажил өөрт болон өрөөлд тус хүргэхээсээ илүү хор уршигтай байдаг.

Гэрийн даалгавраа хийх, хичээлдээ явах, хэн нэгэнд туслахдаа бухимдах сэтгэл төрвөл “Нисгэгч өвгөдийн бодол”-оос санаа авч, өөрийн бодлыг эерэг болгоорой.

1. ХАРИУ НЭХДЭГГҮЙ АЧТАН



Мод яагаад хожуул болдог юм бол?



Эхийг анхааралтай уншаад, агуулгад тохирох нэрийг нь сонгож будаарай.

Өглөгч мод

Алимын мод

Ухаарал

Тусч мод

Эрт урьдын цагт нэгэн алимын мод байжээ. Тэр нэг жаал хүүд маш их хайртай байж. Жаал хүү өдөр бүр модон дээр ирнэ. Тэгээд модны навчсыг цуглуулан титэм хийн толгойдoo өмсөөд, ойн хаан боллоо хэмээн төсөөлнө. Мөн мод руу авирч, мөчир дээр нь тоглоно. Заримдаа алимаас нь амтархан идэж, нуугдаж тоглодог байв. Ядрахаараа харин модны сүүдэрт дугхийнэ.

Жаал хүү модонд үнэхээр хайртай. Мод ч түүнтэй эрхлэн наадахдаа дуртай байлаа.

Цаг хугацаа урсан өнгөрсөөр. Жаал хүү өсөж том болов. Мод ихэнхдээ ганцаараа байдаг боллоо. Нэгэн өдөр хүү модоо эргэн ирэхэд:

- Нааш ир, хүү минь, над дээр авираад, мөчир дээр минь савлаач. Алимаас минь идэж, сүүдэрт минь наадан тоглооч гэсэнд жаал хүү:

- Одоо надад авирч тоглох зав алга. Би юм худалдан авмаар байна. Та надад мөнгө өгч чадах уу? гэжээ.

- Хүү минь, надад май гээд өгөх мөнгө алга. Навч, жимс л байна. Алимуудыг минь хураан авч, хот руу аваачиж зараарай. Тэгвэл чи мөнгөтэй болж, аз жаргалтай байх болно оо гэв.




Хүү алимуудыг нь хураан аваад явжээ. Мод ч баяртай үлдэж гэнэ.
Энэ явдлаас хойш хүү ирэлгүй удаж, алимын мод ч гундан гунигласаар байлаа.

Гэтэл нэгэн өдөр хүү эргэн ирж, алимын мод ч учиргүй их баярлав гэнэ...



Зургуудыг ажиглаж, эхийг үргэлжлүүлэн зохиогоорой.



Мод үнэхээр өрөвдөлтэй хожуул болсон байлаа. Мод хүүг хүлээсээр. Урт хугацаа өнгөрсний дараа хүү модон дээрээ эргэн ирэв.

-Уучил намайгаа, хүү минь. Надад одоо чамд өгөх юу ч үлдсэнгүй. Амтархан идэх алим ч үгүй... хэмээн мод өгүүлэхэд:

- Шүд минь алим даахаасаа нэгэнт өнгөрсөн хэмээн хүү хариулав.
- Савлан тоглох мөчир ч үгүй болсон.
- Мөчир дээр савлах нас минь даанч өнгөрчээ хэмээн хүү өчив.
- Авиран гарах эх бие маань ч байхгүй гэхэд хүү:
- Би авирахгүй, ядарч байна гэлээ.

- Уучлаарай, чамд ямар нэгэн юм өгөх сөн. Даанч надад юу ч үлдсэнгүй. Би зүгээр л нэг муу өвгөрсөн хожуул болжээ хэмээн мод санаа алдан өгүүлэв.

- Надад одоо олон зүйл хэрэггүй ээ. Зүгээр л тайван амарч суух орчин хэрэгтэй. Би маш их ядарчээ хэмээн жаал хүү өчив. Мод

- Нааш ир, хүү минь. Тухлан сууж, сайхан амраад ав гэлээ. Хүү тийнхүү сууж, мод ч баяртай байлаа.





Хүү ямар модон дээр очдог байсан бэ?

алимын мод

шинэс

гацуур мод



Зураг болон харилцан яриаг зөв холбоорой.

Надад модонд авирах зав алга. Надад орон байр хэрэгтэй. Та надад орон байр өгч чадах уу?



Эх биеийг минь огтлон авч, завь хийгтүн. Тийнхүү чи хөвөн одож, баяр хөөртэй байх болтугай.



Уучлаарай, би чамд ямар нэгэн юм өгөх юм сан. Даанч надад юу ч үлдсэнгүй. Би зүгээр л нэг муу өвгөрсөн хожуул болжээ. Намайг уучил.



Асуултын дагуу ярилцаарай.

Эхэд өгүүлэх модыг чи хэнтэй зүйрлэх вэ?

Ээж аав, гэр бүлийнхэн маань ачийг минь хариул гэж хэзээ ч биднээс нэхдэггүй. Гэвч тэднийгээ хүндэлж, баярлуулах хамгийн сайхан.



Тэд чиний ямар тусад хамгийн их баярладаг вэ?


2. ААВ, ЭЭЖИЙНХЭЭ АЧИЙГ ХАРИУЛЪЯ



Зураг ямар утга санааг илэрхийлж байна вэ? Тайлбарлан ярилцана уу.



Ээжийн тань ач юу вэ?



Чи ээжийнхээ ачийг хэрхэн хариулж чадна гэж бодож байна вэ?

Байнга хүндэлнэ

.....

.....

.....



Ээжийнхээ ачийг хариулах юм сан

Би ээжийнхээ ачийг хариулах юм сан гэж боддог боллоо. Ингээд би бууз хийх гэтэл тогоондоо ус хийлгүй буузаа жигнээд бөөн утаа май болов. Бас намайг нэг удаа сургуулиас шагнахад ээж маань их баярлав. Харин ээжийнхээ ачийг хариулсан талаар юм хэлсэнгүй. Ээжийнхээ ачийг хариулах тийм ч амар ажил биш бололтой.

Зун сумын бүх айл хонио ээлжлэн ноослох болов. Ээж халуун өдөр өдөржингөө хонь ноосолж, ядарч туйлдсан байлаа. Тэр зүүн талынхаа орон дээр суугаад:

- Ёох ёх! Балга цай байна уу? гэдэг юм байна.



- Байлгүй яах вэ, би хар цай чанаад тавьчихсан гээд гэрийн сүүдэрт хөргөсөн данхтай цайгаа авч ирлээ. Ээж тэр хар цайнаас хоёр аяга залгилаад,

- Овоо шүү, миний хүү! Ийм л ухаантай шүү дээ. Сайхан цэл хүйтэн цайтай сууж байх юм гэж ээж нь санасангүй. Миний муу бор банди ч ээжийнхээ ачийг хариулж байна даа гэж билээ. Ингэж би ээжийнхээ амнаас анх удаа өөрийнх нь ачийг хариулж байгаа тухай сонсоод гайхсан билээ. Орой нь би эмээгийнхээ очиж энэ тухай ярихад эмээ миний толгойг илбэн

- Хүний тус багаддаггүй юм, хүү минь. Бага ч гэсэн сайн үйл бүтээж, сайхан ажил хийж, хүнд тус болж явбал л ээжийнхээ ачийг хариулж байгаа нь тэр гэж билээ.

Ж.Барамсай “Ээжийнхээ ачийг хариулах сан” өгүүллэгээс



Хүү юу хүсдэг байсан бэ?

- Ээж дээрээ очихыг
- Ээжийнхээ ачийг хариулахыг
- Ээждээ “Баярлалаа” гэж хэлэхийг



Хүү ээжийнхээ ачийг хариулахын тулд юу хийсэн бэ? Эхийг уншаад тохирох хэсгийг тодруулан будаарай.



Ээжийнхээ ачийг хариулах гэсэн хүүгийн хүсэл юугаар илэрч байна вэ? Цэгийн оронд хүүгийн хийсэн үйлийг бичээд үг, үйлдэл, сэтгэлийн аль нь болохыг тохируулан харьцуулаарай.

Үгээр

Ээжийнхээ ачийг хариулъя гэж боддог.

Үйлдлээр

.....
.....
.....

Сэтгэлээр

Хар цай чанаж тавьсан.



Хүү ээжийнхээ ачийг хариулж чадсан болов уу? Тийм бол ачийг нь яаж хариулсан бэ?

.....
.....



Дараах даалгаврыг уншаад, аав, ээжийнхээ ачийг хариулахад хамаарахыг тэмдэглэнэ үү.

Гэрийнхээ ажилд туслах

Өөрийнхөө өрөөг цэвэрлэх

Эрүүл байх

Үгэнд нь орох

Сурлагаа ахиулах

Найзындаа очих

Гэрийн даалгавраа байнга хийх

Биеийн тамир, урлагийн амжилт гаргах

Уурлуулахгүй байх



Чи аав, ээжийнхээ ачийг хэрхэн хариулна гэж бодож байна вэ?
Бодлоо бичээрэй.

Үгээр

.....
.....
.....

Үйлдлээр

.....
.....
.....

Сэтгэлээр

.....
.....
.....

Аав, ээж маань бидэнд хариулж баршгүй их ачтай билээ. Үр хүүхэд нь эцэг, эхийнхээ сэтгэлийг нь зовоохгүй амар амгалан байлгаваас энэ нь ачийг нь хариулж буй хэрэг юм.

Үүний тулд эцэг, эхтэйгээ эелдэг зөөлөн харилцаж, үг сургаалыг нь даган биелүүлж, эрдэм номд шамдан, эцэг, эхээ асран халамжилж, ажил үйлсэд нь туслан, нинжин сэтгэлтэй, бусдад тустай, эрүүл бие, саруул ухаантай зөв сайхан амьдрах хэрэгтэй.

Тусч хүүхдүүд



Зургийг ажиглаж, хийж чаддаг ажлаа тэмдэглээрэй. Хэн гэрийнхээ ажилд хамгийн их тусалдаг вэ?





3. ЭЭЖДЭЭ БИТГИЙ ТУНИРХААРАЙ



Аав, ээждээ уурлан гомдож байсан үе чамд бий юү? Яагаад гомдсон бэ? Үүнд хэн буруутай байсан бэ?



Эхийн хайр


Нанзад найман настайдаа баруун хөлөө гэмтээгээд, гишгэж чадахгүй болжээ. Аав, ээж нь малаа айлд үлдээгээд, хүүгээ дагуулан хот орж эмнэлэгт үзүүлэв. Эмч хүүгийн гэмтсэн хөлд нь чиг барьж боон, хоёр суга таяг тулуулжээ.

Эмч “Хэрэв хүүгийнхээ бүх зүйлийг нь хийж өгсөөр хөдөлгөөний дутагдалд оруулчихвал хөл нь муруй эдгэх юм уу, хазгар доголлон болох аюултай шүү” гэж аав, ээж хоёрт нь анхааруулсан байв.

Аав нь малдаа явахад хүү ээжтэйгээ гэртээ үлдэнэ. Хүү “Суга өвдөөд байна. Энэ хөлийн бэхэлгээ чинь яасан хүнд юм бэ” гэж уйлах өдөр олонтоо.

Гэвч ээж нь түүнийг чадах зүйлээ өөрөө хийхийг байнга шаардана. Хааяа үгэнд нь орохгүй бол “Бэхэлгээ зүүхгүйгээр гишгэлээ, таяг тулалгүй явлаа” хэмээн уурлаж, загнана. Дараа нь харин хүүгээ өрөвдөн гэрийн гадаа гарч сэмхэн уйлдаг байв.

Хожим нь хүү “Хэрэв ээж минь намайг дураар нь тавьж эрхлүүлсэн бол би насаараа тахир дутуу болох байсан биз. Хайр гэж дураар нь байлгахын нэр биш юм даа” хэмээн ухаарчээ.



Асуултын дагуу ярилцана уу.

- Ээж нь хүүдээ ямар шаардлага тавьдаг байсан бэ?
- Хүү хожим нь юуг ухаарсан бэ?



Эхийн утгад ямар зүйр цэцэн үг тохирох вэ?

Аавын бийд
газар үз
Агтны бийд
хүнтэй танилц

Хайр нь дотроо
Хал нь гаднаа

Аавын хүү үг
даадаг
Арвайн гурил ус
даадаг

4. МИНИЙ ТУС



Төрөл саднаа нэрлэнэ үү.




Эхийг уншаарай.

Тусч хүү

Очир зуны амралтаараа хөдөө авга эгчийндээ амарлаа. Амралтын хоногууд уйдах завгүй өнгөрч байгаа нь үнэхээр сайхан.

Нэгэн удаа тугалаа эргүүлэхээр гүйж явтал саахалт айлын өвөө хоёр хувинтай ус барин ирж яваа нь харагдав. Өвөө хөл муутай тул хүнд хувиндаа түүртсэн нь илт. Гар хөлийн үзүүр болдог ач хүү нь эмээтэйгээ сумын төв явсныг Очир мэдэж байсан тул өвөөг угтан гүйлээ. Тэгээд өвөөгийн усыг дөхүүлэн өгч, бас түлээний савыг нь аргалаар дүүргээд, “Өвөө, танд өөр хийлгэх зүйл байна уу?” хэмээлээ. Өвөө ихэд баярлан:

-Болно доо, хүү минь. Аав, ээжийгээ дуурайсан ажилсаг, сайн хүү байна. Дорж, Цэцэгмаа хоёр хүүхдээ зөв хүмүүжүүлжээ гээд толгойг нь иллээ. Айлын өвөөд тусалж, аав, ээжийгээ магтуулсандаа Очир их баяртай байлаа.





Очирыг өвөөд туслахад хэн хэн баярласан бол?



Очир



Ээж



Авга эгч



Аав



Нутгийн өвөө



- Ямар тустай үйл хийвэл аав, ээжийнхээ нэрийг сайнаар хэлүүлэх вэ?
- Чиний сайн үйлээс үүдэн аав, ээж чинь магтуулбал чамд ямар санагдах вэ? Харин муулуулбал ямар байх бол?



Ахмад хүмүүсийг хэрхэн хүндэлж баярлуулах вэ? Нөхөж бичээрэй.



-д явахад нь



өргөж явахад нь



-аар гарахад нь



-г нь



Чамд хэн нэгнийг баярлуулж байсан удаа бий юү? Яаж баярлуулсан бэ?



“Миний тус” эх зохион бичээрэй.

5. НУТГИЙНХНЫ ХҮНДЭТГЭЛ, БАХАРХАЛ



Зургийг ажиглаарай. Чи тэдний тухай юу мэдэх вэ? Тэд монголчуудаа хэрхэн баярлуулсан бэ?



Нутгийнхнаа хэрхэн баярлуулж болох вэ? Энэ талаарх өөрсдийн бодлыг ярилцаад, санаагаа цуглуулж бичээрэй.



Нутаг орныхноо баярлуулж, бахархал нь болсон охины талаарх дараах эхийг уншаарай.

Өгөөмөр сэтгэлт охин



Жамсранжавын Тэгшжаргал охин Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын ерөнхий боловсролын сургуульд сурдаг.

Тэгшжаргал гэр бүлийнхнээрээ их бахархдаг. Тэр аав ээж, хамаатан саднаа хүмүүст туслан, олонтойгоо явахыг багаасаа харж өссөн тул нутгийн түмэндээ чин сэтгэлээсээ тус дэм болохыг зорьдог болжээ.

Монголчууд “Тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас тэвдэж явахад тэвнээр тусал” гэж сургадаг. Өвдөж байхад санаа зовж биеийг нь асуух, өргөж чадахгүйд дэм болж туслах, өлсөж даарч явахад халуун хоол цай хийгээд өгөх, ядарч явахад сонсож сэтгэлийн урам өгөх, зовж, шаналж явахад нулимсыг нь арчиж тайтгаруулах бүгд л тус юм. Тус дэм авсан хүний баярлаж байгааг харах нь түүний аз жаргал.

Тэгшжаргал охин “Анар” дэлгүүрийн худалдагч Д.Болороо болон өвөө

эмээ, анги хамт олноо уриалан сумандаа 107 сайн үйлсийн ажил зохион байгуулж, гачигдал, зовлонтой 85 өрхөд нутгийн сайхан сэтгэлт хүмүүсээс хандив цуглуулан тусалжээ. Гэвч сайхан сэтгэлийн ач тусыг мөнгөөр үнэлэх боломжгүй билээ.

Бусдад тусалж баярлуулах үйлсэд нэгдсэн бяцхан охин ном унших дуртай, бөгөөд тун хөдөлмөрч. Тэрээр олон төрлийн хүнсний ногоо тарьж, даршлан, бас цагаан идээ боловсруулдаг. Мөн хатгамал хатгаж, зүү ороон, тэмээний ноосоор утас ээрч, арьс элддэг гээд түүнд чадахгүй зүйл тун ховор. Сэтгэл байвал юу ч бүтээж болохын илрэл энэ гэлтэй.

Хүн хүнээ гэсэн нандин чанарыг өвлөсөн, энэрэнгүй тусч, ажилч хичээнгүй Ж.Тэгшжаргал охиноор Хэнтий нутгийнхан туйлын их бахархдаг.

“Хэнтийн мэдээ” сониноос.



- Тэгшжаргал охин ямар үйл хийсний учир нутгийнхныхаа бахархал болсон бэ?
- Түүний бүтээсэн үйлд хэн, хэн баярласан бол?



Нутаг усныхнаа хэрхэн баярлуулж болох талаарх санаагаа гүйцээж бичээрэй. Дараа нь ангиараа нэгтгэн ярилцана уу.



Сайн үйл, тусч, энэрэнгүй сэтгэл, хичээл зүтгэлийнхээ үрээр гэр бүл, хамт олон, нутаг усныхан болон улс, эх орныхоо бахархал болсон олон хүүхэд бий. Тэдний нэгийг сонгож, ангийнхандаа танилцуулаарай.

6. БУСДЫГ БАЯРЛУУЛАХ ҮЙЛ



“Аялаарай, амраарай, ярилцаарай” тоглоом тоглоё.

Багшийг “Аялаарай” гэж хэлбэл анги дотроо чөлөөтэй алхаарай. “Амраарай” гэвэл зогсоорой. “Ярилцаарай” гэхэд хамгийн ойр байгаа найздаа түүний хийдэг сайн үйлүүдийг хэлж өгөөрэй.



Ангийнхантайгаа ярилцаад, бусдыг баярлуулах үг, үйлдэл, сэтгэлийг илэрхийлж буй үгсийг ялгаж бичээрэй. Нэмж бичиж болно шүү.

Сайн сурах

Эелдэг байх

Туслах

Хориглосон зүйлийг нь хийхгүй байх

Мэндлэх

Уучлалт гуйх

Спортын амжилт гаргах

Үг, сургаалыг нь дагах

Худал хэлэхгүй байх

Хүмүүжилтэй байх



Ойр дотнын хүмүүсээ баярлуулах төлөвлөгөө зохиогоорой.

	Аав, ээж, бусад төрөл садан	Багш	Нутаг усныхан	Ахмад хүмүүс	Найзууд
Үгээр					
Үйлдлээр					
Сэтгэлээр					



Чи хэн нэгнийг баярлуулахыг хүсэж байна уу? Дараах зураглалыг ашиглан төлөвлөгөөгөө боловсруулаарай.



Бусдыг баярлуулахын тулд хийсэн зүйлээ доорх хүснэгтэд тэмдэглэе. Тэмдэглэлээ ангийнхаа найзуудад танилцуулаарай.

Хэнийг баярлуулсан бэ?	Ямар учраас, яаж баярлуулсан бэ?	Хэзээ баярлуулсан бэ?	Хэрхэн хүлээж авсан бэ?



Бусдыг баярлуулсны ач тус юу вэ? Өөрийн бодлыг бичнэ үү.

- Бусад хүн баярлаж, аз жаргалтай болно.
-
-





“Баян” эмээ

Думбаа эмээг нутгийнхан нь “Баян эмээ шүү” гэлцэнэ. Баян мөртлөө жижигхэн дөрвөн ханатай гэрт амьдардагт нь гайхсан ойр хавийн хүүхдүүд нэгэн удаа түүнээс асуухаар шийдэв.

Зоригтойгоороо чи эхлээд ор гэцгээн, Баатарыг урдаа түлхсээр хэдүүлээ гэрт нь орлоо. Эмээ тэднийг дээшээ суухыг уриад тавагтай идээгээр дайлав. Тэгээд гэрт нь зочилсны учрыг асуулаа.

Баатар “Таныг манай нутгийнхан баян гээд байх юм. Гэтэл танд том гэр, олон хонь ямаа, бас үнэтэй сайхан хувцас байдаггүй шүү дээ. Тэгээд бид таны эд хөрөнгө хаана байдгийг сонирхсон юм, уучлаарай, эмээ” гэлээ.

Эмээ инээмсэглээд “Би та нарт үзүүлье” гээд орон доогуураа шагайснаа нэгэн ууттай зүйл гаргаж ирэв. Бид уутнаас юу гарахыг нь сониучирхан хүлээлээ. Үлгэрт гардаг шиг алт эрдэнэс гарах юм биш байгаа даа...

Уутны амыг нээвэл өнгө өнгийн шагай дүүрэн байлаа. Бүгд гайхан харвал эмээ:

“Өрөөлийг баярлуулсан сэтгэлийн өглөг маань эмээг нь баян болгосон юм даа. Нутаг усныхандаа тусалж баярлуулах бүрдээ энэ уутанд шагай нэмдэг. Шагай нэмэгдэх тусам эмээ нь өөрөө ч баярладаг. Та нар ч бас энэ аргыг хэрэглээд баян болоорой” хэмээн инээмсэглэн хэлээд хүүхдүүдэд хоёр хоёр шагай өглөө.





Асуултын дагуу ярилцаарай

- Думбаа эмээ юугаар баян бэ?
- Хүн юугаар баян байж болох вэ? Гүйцээж бичээрэй.

Сайхан сэтгэл

Хөрөнгө, мөнгө

Эрдэм ном

Үр хүүхэд



Юугаар баян хүн хамгийн аз жаргалтай байх вэ? Яагаад?



“Ертөнцийн гурван баян” юу вэ? Нөхөж бичнэ үү.

Дээд баян

Дунд баян

Адгийн баян

эд хөрөнгө

үр хүүхэд

эрдэм ном



Монголчууд “Ертөнцийн гурван баян”-ыг ийнхүү эрэмбэлсний учрыг ярилцаарай.



Эхэд өгүүлсэн Думбаа эмээгийн адилаар бусдыг баярлуулах бүрдээ уутанд шагай хийн, долоо хоног, сар тутамд тоолж, өөрийгөө урамшуулаарай.



7. ЭВТЭЙ БОЛ МЯНГЫГ ДИЙЛНЭ



Чи дараах үйлдлүүдийн алийг нь дэмжиж байна вэ?
Ширээнийхээ найзтай ярилцаарай.



Найзаараа бахархах



Найзыгаа сонсох



Найзыгаа ичээх



Гомдох, гомдоох



Хамтдаа тоглох



Бусдыг дээрэлхэх



Эелдэг байх



Бусдад туслах



Баярласнаа хэлэх



Хараал хэлэх



Эвтэй байх



Уурлах



Сурагч бүр ширээнийхээ найзын хариултыг ангийнхандаа уншиж
егөөрэй.



Миний найз, байхыг хүсдэг.




Ангиараа ярилцаад дараах баганан зураглалыг хамтран хийгээрэй.

А. Бусдад туслахыг хүсдэг хүүхдүүд байна уу? Хоёр гараа өргөөрэй.

Б. Эвтэй байхыг хүсдэг хүүхдүүд байна уу? Босоорой.

В. Бусадтай эелдэг харилцахыг хүсдэг хүүхдүүд байна уу? Суугаарай.

Г. Хамтдаа тоглохыг хүсдэг хүүхдүүд байна уу? Алгаа ташаарай.



Баганан зураглалыг ажиглаад хамгийн өндөр баганыг олоорой.



Гарсан үр дүнг нэгтгэж бичээрэй.

Бидний хүсэл – эвтэй байх,, ..
.....,



Эвтэй байхын ач тус юу вэ? Бодлоо бичнэ үү.

Миний бодлоор:

.....
.....
.....



Эвтэй байхын тулд юуг анхаарах вэ? Ангиараа ярилцаж, шийдэлд хүрээрэй.




Нэгдсэн шийдлээ “Ангийн дүрэм”-дээ нэмж, сурагч бүр хэрэгжүүлээрэй.

8. ЭВ ЭЕ



- Зурагт юуг дүрсэлсэн байна вэ?
- Зургийн агуулгад тохирох зүйр үгийг олж ярилцана уу.



Эвийн хүч



Эрт цагт монгол овог аймгууд өөр хоорондоо тэмцэлдэн тулалдаж, ард иргэд нь дайны хөлд туйлын ихээр зовж байжээ. Харин энэ үед олон удаагийн тулаан хийж, хамаг монголыг нэгтгэн, энх тайвныг тогтоож чадсан хүн бол Чингис хаан буюу Тэмүжин билээ. Тэр дотооддоо төдийгүй бусад улстай эв найрамдалтай байхыг хичээнэ. Гэвч бусад улс зөрчилдөн тэмцэлдсээр байв.

Тухайлбал, худалдаа хийхээр очсон монгол худалдаачдыг Хорезм улсын нэгэн ноён хороожээ. Тэр цагт Хорезм улс Ази, Европыг холбосон өргөн уудам газар нутгийг эзлэн оршдог, маш хүчирхэг гүрэн байлаа. Тиймээс Хорезмын хаан сүр хүчиндээ эрдэн, өөрсдийн бурууг хүлээсэнгүй. Чингис хаан үг хэлээр үл ойлголцох, дээрэнгүй зантай Хорезмын хаантай дайтахаас өөр аргагүй болов. Тухайн үед Хорезмын хаант улс дотроо эв нэгдэлгүй байв. Бүх хүчээ нэгтгэн тулалдах түшмэдийнхээ саналыг хаан нь сонссонгүй. Цэрэг, түшмэд нь нэг дор цугларвал өөрийнх нь эсрэг үгсэн хуйвалдаж, өөрөө бас олон ноёд, түшмэдээ нэгтгэн захирч чадахгүй байх хэмээн Хорезмын хаан эмээж байв. Тиймээс дор бүрнээ өөр өөрийн хотыг хамгаалан тулалдах зарлиг буулгажээ. Энэ нь цөөн тоотой монгол цэрэгт ашигтай байв. Учир нь Чингис хааны цэрэг олон цэрэгтэй их хүчний эсрэг шууд тулалдахын оронд цөөн цэргийн эсрэг байлдаж, хот хотоор нь эзэлсээр Хорезм улсыг өөрийн захиргаанд оруулжээ.

Чингис хаан Монгол туургатныг нэгтгэн эвсүүлээд зогсохгүй, дээр өгүүлснээр дотроо зөрчилтэй байсан олон хөрш улс орны дотоодын дайн самууныг зогсоон, өөртөө нэгтгэн захирч, өнөөгийн даяаршлын эхлэлийг тавьсан Монголын эзэнт гүрнийг байгуулсан билээ.

*“Монголын нууц товчоо”-ноос
сэдэвлэн зохиомжлов.*





Асуултын дагуу нөхөж бичээрэй.

Хорезмын хаанд тулгарсан асуудал	→ Хэрхэн шийдвэрлэсэн бэ?	→ Үр дүн нь юугаар илэрсэн бэ?



Асуултын дагуу ярилцаарай.

- Чингис хааны цэрэг ялалт байгуулахад эсрэг талаас нөлөөлсөн зүйл юу вэ?
- Чингис хааны цэргийн давуу тал юу байсан бэ?



“Эв зөийг эрхэмлээгүйн хор уршиг” сэдвээр хэлэлцээрэй.

Хэлэлцүүлэг хийх аргачлал:

4-6 сурагч нэг багт хуваагдана.

Цаасны голд хэлэлцүүлгийн сэдвийг бичнэ. Доор нь бичих хангалттай зай үлдээгээрэй.

Цаасыг багийн гишүүдийн тоогоор тэнцүү хэсэгт хуваана.

Хэсэг тус бүрд нэг нэг сурагч сэдвийн дагуу өөрийн бодлыг бичнэ.

Хүүхэд бүрийн бичсэн бодлыг багаараа хамтдаа уншаарай.

Эцэст нь цаасныхаа голд багийнхны бодлыг нэгтгэж бичээрэй.

Нэр
Миний бодол

Нэр
Миний бодол

Эв зөийг эрхэмлээгүйн
хор уршиг

.....
.....

Нэр
Миний бодол

Нэр
Миний бодол



Танай ангид эв эеийг эрхэмлээгүйн улмаас гарсан бэрхшээлтэй асуудал байсан уу? Уг асуудлыг хэрхэн шийдсэн бэ? Шийдэл нь зөв байж чадсан уу?



Чи эв эеийг эрхэмлэдэг үү? Өөрийгөө сориорой.

№	Асуулт	Тийм	Үгүй	Хааяа
1	Би ангийнхаа найзуудтай эвтэй байдаг.			
2	Манайд хамаатан садны маань хүүхдүүд ирэхэд би эвтэй байж чаддаг.			
3	Хэн нэгэнтэй муудалцсан үедээ би тайван байдаг.			
4	Би найзтайгаа муудалцсан ч уучилж эвлэрдэг.			
5	Би ангидаа ч эвтэй, гэрийнхэнтэйгээ ч эвтэй байдаг.			
6	Манай ангийнхан муудалцвал би оролцдоггүй.			
7	Бусдын бодол санаа чухал гэж би боддог.			
8	Хамт тоглох, хичээлээ хийх, ангиараа тэмцээнд оролцох үедээ бид улам эвтэй болдог.			
9	Би хүүхдүүдтэй эвтэй, найрсаг байхыг хүсдэг.			
10	Эв зетэй байх талаар би бусдад үлгэрлэж чадна.			
Хариултуудын тоогоо нэгтгээрэй.				



Хариултаа тэмдэглээд, өөртөө дүгнэлт хийгээрэй.

Эв зегүй бол Хорезмын хаан шиг ялагдал хүлээхэд амархан байх болно.



9. УУЧЛАХ СЭТГЭЛ



Уучлал гэж юуг хэлэх вэ? Бусдыг үнэхээр уучилсан эсэхийг нь яаж мэдэж болох вэ?



Анхааралтай уншаад, цэгийн оронд тохирох үгийг нөхөж бичээрэй.
Өөрийн болон бусдын буруу үйлдэл, алдаанд эерэг, уужуу сэтгэлээр хандаж,
..... тээхгүй байхыг гэнэ.

Гомдол	Талархал	Уучлал
--------	----------	--------



Хүүхдүүд завсарлагаанаар гадаа тоглож байлаа. Бөмбөгөөр тоглож байсан Чимгээг Төмөрөө дайрч унагаад босгосонгүй гүйгээд явчихлаа. Чимгээ уйлж байтал Саран ирж учрыг нь асуув. Болсон явдлыг сонсоод Саран “Яасан юм бол доо? Төмөрөө сайн хүүхэд шүү дээ. Учрыг нь мэдэх хэрэгтэй” гэжээ.

Хичээлийн дараа Төмөрөө Чимгээ рүү ирээд “Чамайг унагаасанд уучлаарай. Нөгөө ангийнхан шоолоод, би их ууртай байсан юм. Тэгээд л муухай зан гаргачихлаа” гэв.




Төмөрөө Чимгээг унагаасныхаа дараа яагаад уучлалт гуйгаагүй вэ?

Уучлалт гуйхгүй, эсвэл уучлахгүй бол хүмүүс эв эетэй байж чадахгүй.




Дараах тохиолдолд хэрхэх вэ? Гүйцээж бичнэ үү.





Дараах жишээг шинжилж, хүснэгтийг нөхөж бичээрэй.



Жишээг шинжилснийхээ үр дүнг ангийнхантайгаа ярилцаарай.

- Уучлахгүйгээр эв зетэй байж чадах уу?
- Уучлалт гуйхгүй, эсвэл бусдыг уучлахгүй бол юу болох вэ?



Ангиараа ярилцаад дүгнэлтээ бичээрэй.

.....

.....

.....

.....



Аав, ээж, ах эгч, гэр бүлийнхнээсээ хэн нэгэнд гомдоод уучилж байсан тохиолдлыг нь асууж, уучлахаас өмнө, уучилсны дараа ямар байсан тухай яриулаарай.

10. УУЧЛАЛТ ХЭРХЭН ГУЙХ ВЭ?



Уучлалт гуйж, гэмшиж буйгаа үг, үйлдлээр илэрхийлж болдог. Хэрэв чи хэн нэгнээс уучлалт гуйхыг хүсвэл яах вэ?

.....

.....

.....

.....



Уучлалт гуйх доорх үг хэллэг, үйлдлүүдийг ялгаж бичээрэй. Өөрийнхөө бодлыг нэмж бичиж болно шүү.

Юу гэж хэлэх вэ?	Юу хийх вэ?

Намайг уучлаарай. Уурыг нь гарахыг хүлээнэ. Чи намайг уучлах уу?
 Миний буруу. Уучлалт гуйж захидал бичнэ.
 Би маш их гэмшиж байна. Би буруугаа сайн ойлгож байна.
 Уучлалт гуйж баярлуулах зүйлийг нь хийж өгнө.



Уучлалт гуйхад нь туслаарай.

Тэлмэн Энхжингийн дугуйг унаж байгаад эвдэлчихжээ.
 Тэлмэн алдаагаа засахыг хүсэж байна.



- Тэлмэн яаж уучлалт гуйж болох вэ?
- Энхжин уучлах болов уу? Уучлахгүй байх нь ямар муу үр дагавартай вэ?



Хэрэв чи хэн нэгнээс уучлалт гуйхыг хүсэж байгаа бол хэзээ ч оройтохгүй. Дараах алхмын дагуу уучлалт гуйгаарай.

Уучлалт гуйх алхам	Уучлалт гуйхдаа
1. Буруугаа хүлээн зөвшөөрөх	Буруутай гэдгээ хүлээх
2. Чин сэтгэлээсээ уучлалт гуйх	Уучлалт гуйж буйгаа гомдоосон хүнийхээ сэтгэлд хүрэхээр илэрхийлэх
3. Алдаагаа засах, дахин давтахгүй байх	Алдаагаа дахин давтахгүй байж, амлалтдаа хүрэх

11. САЙН НАЙЗ



Хамгийн сайн найзтайгаа удаан хугацааны дараа уулзах үед чамд ямар санагддаг вэ?



Асуултын дагуу ярилцаарай.

- Сайн найз чинь чамайг гомдоож байсан тохиолдол бий юү?
- Чи найзыгаа уучилсан уу? Яагаад?





Уучлалын салхи

Дотнын хоёр найз аян замдаа явахдаа ам мурийж, нэг нь нөгөөгөө алгаджээ. Алгадуулсан найзынх нь хацар тун их өвдсөн боловч юу ч хэлэлгүй “Өнөөдөр миний хамгийн сайн найз намайг алгадлаа” гэж элсэн дээр бичив.

Цааш явсаар цөлийн дундах нэгэн баян бүрдэд ирж, усанд орж амрахаар шийджээ. Усанд орох гэтэл алгадуулсан найз нь гэнэт намагт шигдэв. Намаг түүнийг агшин зуур хүчтэй сорон доошлуулж байлаа. Үүнийг харсан найз нь үтэр түргэн ирж найзыгаа намгаас татаж гаргажээ.

Аврагдсан найз нь нэгэн том хадан дээр “Миний хамгийн сайн найз намайг аварлаа” гэж бичлээ.

Найзыгаа алгадаж, дараа нь аварсан найз нь “Чамайг алгадахад элсэн дээр бичсэн атал аврахад минь яагаад хадан дээр сийлж байгаа юм бэ?” гэж асуув. Найз нь “Хэн нэгэн бидэнд муу зүйл хийхэд түүнийг сэтгэл дотроо элсэн дээр бичих хэрэгтэй. Уучлалын салхи түүнийг туун арилгана. Харин хэн нэгэн сайн зүйл хийх юм бол чулуун дээр сийлэх хэрэгтэй. Тэгвэл ямар ч салхи хийсгэн арилгаж үл чадна” хэмээн хариулжээ.

Сургамжит өгүүллэгээс



Төсөөлөн бичээрэй.

Хэрвээ чи
алгадуулсан
найзын оронд
байсан бол

Юу гэж бодох вэ?

Юу гэж хэлэх вэ?

Найзыгаа уучлах уу? Яагаад?



Алгадуулж бас авруулсан найзын үйлдэл зөв үү?

Миний бодлоор түүний Яагаад гэвэл,



- Бусдыг уучлахын ач тус юу вэ?
- “Уучлахын ач тус” сэдвээр хэлэлцүүлэг хийцгээе.

Хэлэлцүүлэг хийх аргачлал

- Өөрт тохиолдсон зүйл, жишээ, чухал санаануудыг ээлжлэн ярина.
- Хүн бүр юу гэж бодож байгаагаа хэлнэ.
- Бүгдээрээ сонирхсон, сайн гэж үзсэн нэг жишээг сонгоно.
- Дээрх жишээгээ тодруулан хэлэлцэж, илүү сайн ойлгохыг хичээнэ.
- Бусдыгаа сайтар сонсож, ойлгоогүй бол асууна.
- Багш яриаг чиглүүлэх боловч, өөрийн бодлыг хэлж оролцохгүй.
- Багш зарим чухал санааг самбарт бичнэ.
- Тус сэдвийн талаар бүгд хүлээн зөвшөөрсөн, нэгдсэн нэг ойлголтод хүрнэ.
- Хэрхэн хэлэлцсэн тухайгаа дүгнэж ярилцана.

Уучлах нь ууч сэтгэлээс үүдэлтэй. Ухаантай хүн л уучилдаг.
 Бусдыг ойлгож, уучилдаг хүний бие эрүүл, сэтгэл санаа амгалан,
 амьдралдаа идэвхтэй, эрч хүчтэй байдаг.

12. ЗӨВИЙГ ДАГАЯ



Бусдын үг, сургаалыг биелүүлэхийн тулд юу, юу хийх ёстойг зөв дарааллаар нь дугаарлаарай.



Дараах тохиолдолд чи хэрхэн шийдэх вэ?

- Гэрийн даалгавар хийж амжихгүй байсан тул чи дэндүү оройтлоо. Тэгтэл эмээ чинь:
 - Миний хүү, одоо боль, боль. Бүр ядарчихлаа. Хүүхдүүд бүгд даалгавраа хийж ирдэг юм уу даа. Хааяа даалгавраа хийхгүй байж болно шүү дээ гэв.

Эмээгийнхээ үгийг дагана. Яагаад гэвэл:	Эмээгийнхээ үгийг дагахгүй. Яагаад гэвэл:



- Өглөө босоход цас нэвсийтэл дарсан байв. Ээж чинь:
 - Гадаа хүйтэн байна. Миний охин өнөөдөр хичээлдээ яваад яах вэ? Хүргэж өгч ч чадахгүй нь. Багшид чинь өвчтэй гээд хэлчихье гэлээ.

Ээжийнхээ үгийг дагана. Яагаад гэвэл:	Ээжийнхээ үгийг дагахгүй. Яагаад гэвэл:



Томчууд ч заримдаа буруу үг хэлдэг. Тэдний үгэнд эргэлзэх үе чамд тохиолдож байсан уу? Чи алдааг нь хэлэхийг хүсэж байсан уу?

Тэдний хэлж болох буруу үг	Миний хэлэх үг
.....



Заримдаа тэд бас буруу зүйл хийдэг. Хүснэгтийг нөхөж бичээрэй.

	Байнга таардаг	Хааяа таардаг	Огт таардаггүй	Томчуудад хэлэх бидний үг
Автобусны буудалд тамхи татах			
Голд машинаа угаах			
Гудамжинд хог хаях			
Хоорондоо муудалцах			
Гарцгүй газраар хүүхдээ хөтөлж гарах			
Хашааны буланд бие засах			
Малаа зодох			

Томчуудын буруу үг, үйлдэлд хэрхэн хандах вэ?

Хэрэв ойр дотнын болон таньдаг томчууд чинь буруу үг хэлэх юм уу, буруу үйлдэл хийвэл “Ах аа, эгч ээ, тэгж болохгүй шүү дээ” гэж эелдгээр хэлж болно. Харин гудамжинд огт танихгүй хүнд шууд хэлэхээс болгоомжлоорой. Учир нь уурлах хүмүүс бас бий.

Харин буруу зүйлийг байнга хийж байгаа хүн харагдвал ойр дотнын зөвлөж туслах том хүнд хэлэн, асуудлыг шийдүүлээрэй.

1. МОНГОЛ ДЭЭЛ



Чи дээлээ хэдийд өмсдөг вэ?

байнга өмсдөг

огт өмсдөггүй

хөдөө явахаараа өмсдөг

наадмаар өмсдөг

цагаан сараар өмсдөг

монгол хувцасны өдрөөр өмсдөг



Шинэ дээл

Аав ээж, эмээ өвөө, Амгаа ах гээд бид бүгд дээл өмсдөг. Харин энэ жил миний дээл багадчихжээ. Ээжид шинэ дээлтэй болмоор байгаагаа хэлсэн ч төдий л тоосонгүй.

Гэтэл нэг өдөр эмээ маань намайг дуудлаа. Гүйгээд ортол цоо шинэхэн дээл гаргаж ирээд “За, миний хүү, таарах нь уу, үз дээ” гэв. Би баярлан хурдхан өмсөж үзлээ. Надад яг таарч, өнгө нь ч зохисон байв.

Дээлээ эмээгээрээ бүслүүлж байтал ээж маань гаднаас орж ирээд инээмсэглэн: “Сайхан таарч шүү. Хүүгээ гэнэт баярлуулах гээд ээж нь хэлээгүй юм” хэмээлээ. Эмээ “Хүүгийнхээ шинэ дээлийг мялаая” гээд хормойг минь засаад:

“Урд хормой дээр чинь

Унага даага гишгэл

Хойд хормой дээр чинь

Хонь хурга харайлд

Дотоод хормой дээр чинь

Тос өөх наалдаг

Эд нь хэврэг

Эзэн нь мөнх

*Энэнээс сайхныг эдэлж
яваарай”* гэж ерөөгөөд, атга дүүрэн чихэр өгөв. Харин би дүүдээ хуучин дээлээ өгөөд, чихрээ хувааж идлээ.





Шинэ дээлийн мялаалга ямар утгатай байна вэ? Зөвийг тэмдэглэнэ үү.

- Хүүхэд багачуудыг баярлуулж бай гэсэн утга.
- Өмссөн хувцсаараа бус сурсан эрдмээрээ бахарх гэсэн утга.
- Эд хувцас элэгдэж хуучирдаг, эзэн хүн нь мөнх байг гэсэн утга.
- Элбэг баян, сайхан амьдраарай гэсэн утга.



Нөхөж бичээрэй.

Урд хормой дээр чинь

.....

Хойд хормой дээр чинь

.....


Дотоод хормой дээр чинь

.....

Эд нь

Эзэн нь

.....эдэлж яваарай!



Шинэ дээлийн мялаалгын үгийг цээжлээрэй.



Дээлтэй холбоотой цээрлэх ёсыг мэдье.

- Дээлийн энгэр, заамыг бүрэн товчилж өмсөн золгодог. Энэ ёсыг дагахгүй бол үл хүндэтгэснийг илэрхийлнэ.
- Дээлийн хормойг шуудаггүй.
- Дээлийн ханцуйг дотогш нь нугалдаггүй. Нугалах нь хэн нэгэнтэй зодолдох гэсэн санаа агуулдаг.
- Дээлийн захыг уруу нь харуулж тавьдаггүй. Учир нь өвчин зовлон дуудна гэж үздэг.



Нөхөж бичнэ үү.

Дээлийн энгэр заамыг бүрэн товчилж золгодгийн учир:

Дээлийн ханцуйг дотогш нугалдаггүйн учир:

Дээлийн хормойг шуудаггүйн учир:



“Монгол дээл, хувцастай холбоотой ёс, цээр” сэдвээр мэдээлэл, зураг цуглуулаарай.



Ажлынхаа үр дүнг нэгтгэж, багаар ярилцаарай.

2. САЙХАН ШИНЭЛЖ БАЙНА УУ?



Дараах үгс ямар баяртай холбоотой байна вэ?

төрөл садан, зочин гийчин, ууц шүүс, бэлэг авах,
хэвийн боов, мөр гаргах, нар харах, хөөрөг даалин,
бууз банш, хадагтай золгох, айлд зочлох, монгол
хувцас, тавгийн идээ



Цагаан сар

Цагаан сар болох дөхөж байлаа. Нэгэн үдэш өвөө маань “Хэрлэн! Миний охин нааш ирээч. Чи өчигдөр Цагаан сарын тухай асуугаад байсан даа. Одоо тэр тухай зурагтаар гарч байна” гэв. Би хурдан гүйн, зурагтын өмнө очлоо.

Цагаан сар нь монгол хүн бүрийн нас нэмсэн, өвлийг өнтэй давж, урин хавартай золгосон, хуучин он өнгөрч, шинэ он гарсны гурван давхар баяр юм. Тиймээс энэ баяраар монголчууд хамгийн эрхэм нандин үгээ хэлэлцэн сайн сайхныг ерөөж шинэлдэг. Шинийн нэгний өглөө нар мандахаас өмнө босно.

Хамгийн ахмад хүнтэйгээ эхэлж золгох бөгөөд хадгийн амыг золгож буй хүн рүүгээ харуулна. Золгохдоо хоёр гараа дэлгэн, ахмад хүнээ хүндлэн тохойг нь түшиж золгодог нь сайн сайхан сэтгэлээр мэндэлж байна гэсэн утгатай. Цагаан сараар нэг нэгэнтэйгээ муудалцах, хараалын үг хэлэх зэрэг муу муухай бүхнийг цээрлэдэг.

Зурагтын нэвтрүүлгээс би олон асуултынхаа хариултыг авсан юм даа.



Асуултын дагуу ярилцаарай.

- Цагаан сар ямар давхар баярыг илтгэдэг вэ?
- Золгохдоо хоёр гараа дэлгэн, алгаа дээш харуулдаг нь юуг бэлгэддэг вэ?
- Цагаан сараар ямар үйл хийхийг цээрлэдэг вэ?



Дөрвөн багт хуваагдан дараах сэдвүүдээс сугалж, мэдлэгээ сорьцгооё.

Баг бүр сугалсан сэдвийнхээ дагуу бусдаасаа асуух асуулт бэлдэнэ. Харин хариултаа өөрсдөө мэдэж байх учиртай.

Зөв хариулт бүр нэг оноо авах бөгөөд хариулж чадаагүй асуултын оноо нь асуулт асуусан багт үлдэнэ.

Битүүлэх ёс

Идээ, шүүс
тавих ёс

Золгох ёс

Цээрлэх ёс

3. ЦАГААН САРЫН ИДЭЭ




Зургийг ажиглаад, аль нь монголчуудын уламжлалт баяр болохыг тэмдэглэнэ үү.



Цагаан сарын баярын ширээг хэзээ засдаг вэ? Цагаан сарын ширээн дээр ямар ямар идээ тавьдаг вэ?



Доорх ширээн дээр цагаан сарын идээг зөв зассанаар зураарай.





Баянаа хүү “Аав аа, өвөөгийнх тавгийн идээгээ зассан байна. Манайх ч гэсэн засах уу?” гэсээр орж ирлээ. Тэгснээ “Өвөөгийнх ийм өндөр таваг зассан. Манайх тэрнээс ч өндрийг засна шүү” гэлээ. Аав нь инээгээд “Хүү минь, өвөө эмээ шиг нь ахмад настнууд л идээгээ долоо, есөн үеэр өрдөг юм. Харин залуу хүмүүс түүнээс цөөн үеэр засдаг ёстой” хэмээлээ.

Ингээд нар шингэмэгц ээж нь битүүлгийн ширээг засаж, идээ шүүсээ тавин, цайныхаа дээжийг аавд нь эхэлж барив. Аав нь битүүлгийн шүүсийг хөндөж, галдаа өргөөд, хүүхдүүддээ хувь хүртээлээ.



Монголчууд цагаан сарын тавгийн идээгээ ааруул, бяслаг, өрөм, тос зэрэг цагаан идээгээр засдаг уламжлалтай. Хожим цагаан идээний хамт самнаа, гүрмэл, хэвийн боовоор засдаг болжээ.

Баяр ёслолын идээг сондгой үеэр засдаг. Энэ нь идээний үе бүрийг “жаргал, зовлон, жаргал” хэмээн нэрлэдгээс үүдэлтэй. Баярын ширээний идээ жаргалаар эхэлж, жаргалаар дуусахыг бэлгэддэг.



Хэнийх тавгийн идээгээ хэдэн үе зассан бол?





Өгүүлбэрийг гүйцээж бичээрэй.

Тавгийн идээг сондгой үеэр засдагийн учир нь

.....




Цагаан сарын тавгийн идээг ямар идээгээр засдаг вэ? Холбож зураарай.



4. ЦАГААН ИДЭЭ




Зурагт ямар ямар цагаан идээ байна вэ? Нэрлэж бичнэ үү.



.....

.....

.....



.....

.....



Ааруулд дуртай хүү


Чингүүн ааруулд дуртай. Ээж, аав нь түүнд:

- Миний хүү ааруул идвэл шүд нь бөх болно. Ааруул бас өлсгөхгүй, эрүүл мэндэд тустай хэмээн ухааруулжээ. Чингүүнд хорхойтсон шүд ганц ч үгүй. Харин түүний сайн найз Бямбаа чихэр их иддэг. Тиймээс шүд нь үе үе өвдөж, эмнэлэг явах болжээ.



Асуултын дагуу ярилцаарай.



- Чингүүний шүд яагаад эрүүл байна вэ?
- Яагаад Бямбаа найз нь эмнэлэгт үзүүлэх болов?
- Ааруул өөр ямар ач тустай вэ?





Дараах эхийг уншиж, тохирох нэг үгийг нөхөж бичээрэй.

..... нь цагаан идээний нэг төрөл бөгөөд монголчуудын уламжлалт хүнсний бүтээгдэхүүн юм.-ыг хийхдээ буцалгасан тараг, цагааг тусгай уутанд хийн шүүж, аарц гарган авна. Уг аарцаа бага зэрэг сүүгээр амтлаад, базах, шахах, шүүх, хэвлэх зэргээр нягтруулаад зүсэж, дэлгэцэн дээр тавин наранд хатааж хийдэг.



Цагаан идээний талаарх мэдлэгээ нэмээрэй.

Монголчууд сүүгээр олон төрлийн цагаан идээ хийдэг. Цагаан идээнд ааруул, аарц, айраг, бяслаг, өрөм, тараг, хоормог, хурууд, цагаан тос, шар тос, ээдэм, ээзгий зэрэг малын сүүгээр хийсэн бүтээгдэхүүн цөм багтана.

Эдгээрийг боловсруулах арга маш нарийн. Тухайлбал, цагааг цагаан ямбуу уутанд хийж, шар усыг нь шүүж аарц гарган авна. Хонь, ямаа, үхрийн сүүг хөөрүүлэн самарч хөөсрүүлээд, аргал, түлээний цог дээр загсаасныг өрөм гэнэ. Өрөм, зөөхийг гүзээ зэрэг саванд хураан хадгалбал цагаан тос болно. Цагаан тосыг хайлж, шар тос гаргаж авна. Сүүг тараг, цагаагаар эдүүлээд шар сүүг нь авалгүй зөөлөн галаар буцалгахад ээзгий болно.



Асуултын дагуу ярилцаарай.

- Чи ямар цагаан идээнд дуртай вэ?
- Ямар цагаан идээ хийх аргыг мэдэх вэ?



Амт, чанартай цагаан идээ хийх аргыг бичиж, зургийн хамт ангийнхандаа танилцуулаарай.

5. ХӨХҮҮРИЙН АЙРАГ



Гүүний сүүг юу гэж нэрлэдэг вэ?

Тараг

Саам

Хоормог



Адууны ач тус, ашиг шим юу вэ?


саам

.....

.....

.....

.....



.....

.....

.....

.....



Шүлэгт айраг ямар ашиг тустайг дүрсэлсэн байна вэ?

Хөхүүрийн айраг

Айлын ах айлчлахад нь
Айргаа барин дайллаа.
Ай даа, мөн ч сайхан шүү гээд
Аав руу маань талархан харлаа.
Амсаад үзэхэд исгэлэн
Айраг гэдэг энэ ундаанд
Ах аа, та яагаад
Ийм дуртай юм бэ гэж
Аавыгаа гарсан хойгуур

Асууж би амжлаа.
Амсахад хэдий гашуун ч
Амин дэмээр баялаг
Гэдэс ходоод, уушги зүрхэнд
Гэмгүй сайн ундаа даа.
Хөхүүртэй айраг бол
Харин ч нэг эм шүү гэж
Ах надад учирлан хэлээд
Айргаасаа ахин балгалаа.



Эхийг уншаад айраг хийх аргыг мэдэж аваарай.

Монголчуудын эрт үеэс уламжлан хийж, хэрэглэж ирсэн хүндэтгэлт идээ, ундааны нэг нь айраг юм. Гүүнээс саасан сүүг ширэн хөхүүрт хийж, модон бүлүүрээр тос гартал бүлж, айргийг исгэнэ.

Айраг нь өвчин анагаах чадалтай, исгэлэн амт, сэнгэнэсэн үнэртэй, шим тэжээлээр баялаг, биед түргэн шингэж боловсордог ундаа юм.



Айраг исгэх аргыг зөв дараалалд оруулж дугаарлана уу.

Саамаа
хөхүүрт хийх

Гүүгээ саах

Айргаа бүлэх


Гүүгээ барих



Гүүний айргийн ашиг тус юу вэ? Дээрх эхэд байгаа айргийн ашиг тусын талаарх хэсгийг ялгаж бичээрэй.







Айргийг аль саванд хадгалах нь зөв бэ? Яагаад?







Аль нь айргийн ямар зориулалттай сав бэ? Ялгаж, нэрлээрэй.



6. МИНИЙ ДУРТАЙ ТАРАГ



Дараах түргэн хэллэгийг хэн нь хурдан хэлэх вэ?

Арын арван таван тарган тарлан
 Хар сарлагийн таргийг
 Тараг биш гэж эс уугаад
 Ямар арын таван тарган тарлан
 Хар сарлагийн таргийг
 Тараг мөн гэж уух вэ?



Харьцуулан уншицгаая.

Эмээгийн бүрсэн тараг	Ээжийн авч өгсөн тараг
<p>Би эмээгийнхээ бүрсэн тарагт дуртай. Эмээ минь хавар болохоор надад шинэ тараг бүрж өгдөг.</p> <p>Эмээ тараг бүрэхдээ хөөрүүлсэн сүүг зөөлөн гал дээр халааж, халбага төдий таргийн хөрөнгө нэмж самарна. Сүүгээ самрахдаа хурууныхаа өндгөн дээр дусааж, халуун, хүйтнийг нь тохируулж үздэг. Тэгээд сүүгээ паалантай саванд уудалж таглаад, гадуур нь дээлээр хучиж, эхэлж хоймрын авдрын өмнө, дараа нь нар дагуулан тавьдаг юм. Цаг орчмын дараа сайхан элгэн тараг бүрэлддэг дээ.</p> <p>Эмээ маань сарлагийн сүүгээр бүрсэн тараг илүү амттай болдог гэж хэлдэг.</p>	<p>Ээж маань надад дандаа тараг авч өгдөг. Би тараг уух дуртай ч ямар ач тустайг нь мэддэггүй байсан юм. Гэтэл нэг удаа ээж маань “Чи үүнийг унш даа” гэсээр таргийн сав өглөө. Би гайхангуй аваад үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> -Тараг шүд хорхойтох, чулуужих, буйл үрэвсэхээс сэргийлнэ. Тиймээс сайхан шүдтэй байхыг хүсвэл тараг уугаарай. -Тараг ходоод, гэдэсний үйл ажиллагааг сайжруулж, гэдэс өвдөхөөс сэргийлнэ. -Тараг дахь кальци, уураг нь яс бэхжүүлж, хүүхдийн өсөлтийг дэмжинэ. -Тараг хоол шингээж, тайвшруулна гэжээ. <p>“Тараг ийм их ач тустай болохоор л чамд өгдөг юм шүү дээ” гэж ээж минь хэллээ.</p>



Эхүүдэд юуны тухай өгүүлсэн байна вэ? Товч дүгнэж ярилцана уу.

Эмээгийн бүрсэн тараг	Ээжийн авч өгсөн тараг



Тараг бүрэх аргыг нөхөж бичээрэй.

Хөөрүүлсэн сүүг галаар халаана.

.....төдий таргийн хөрөнгө нэмнэ.

..... хүйтнийг нь тохируулна.

Паалантай саванд уудалж

..... дагуулан тавина.



Гэртээ тараг бүрж үзээрэй. Ямар орц найрлагатай, ямар хугацаанд бүрэлдсэн, ямар амттай болсныг ангийнхандаа танилцуулаарай.



Таргийн ач тус юу вэ? Үргэлжлүүлж бичээрэй.


- Шүд үрэвсэхээс сэргийлнэ. - Яс бэхжүүлнэ. -




Таргийг ямар малын сүүгээр бүрдэг вэ? Зөвийг сонгоорой.



Эм хонь



Үнээ



Эм ямаа



Ингэ



Гүү




Сарлагийн үнээ



Үхрийн тухай дараах мэдээллүүдийг дэлгэрүүлэн лавлаж, үр дүнг нь ангийнхандаа танилцуулна уу.

Мах, сүү,
хөөвөр,
хялгасыг нь
ашигладаг.



Тэргэнд хөллөж, уналга
ачлагад хэрэглэнэ.

Монгол үхэр, сарлаг,
хайнаг, ортоом зэрэг
төрөлтэй.

Хар, улаан, цагаан, хөх,
бор, алаг, тарлан гэх мэт
зүстэй.

Үхрийг өөв өөв гэж
дуудан, хөж хөж гэж
туудаг.

Нэг настайг тугал, хоёр настайг
бяруу, гурван настай эрийг гуна,
эмийг гунж, дөрвөн настай эрийг
дөнө, эмийг дөнж, нас гүйцсэн
эмийг үнээ, засаагаа авхуулсан эр
үхрийг шар гэнэ.



Шүлгийг уншаад, мал амьтныг хайрладаг уламжлалт ёсны талаар ярилцаарай.

Тугалаа битгий зодоорой

Хөөрхөн алаг тугалаа
Хөөж элдэж болохгүй шүү
Хөхөж цаддаг сүүнээс нь
Хөөрүүлж чи уудаг шүү
Сартай улаан тугалаа
Саваагаар цохиж болохгүй шүү

Саам сайтай эхийнхээ
Сайхан сүүнээс нь өгөхгүй шүү
Улаан тугалаа зодчихоод
Уурыг нь чи хүргэчхээд
Уураг цагаан сүүнээс нь
Уувал чи муухай шүү.

Ч.Лхамсүрэн



7. МОНГОЛ БӨХ



Зураг дахь бөхийн өмсгөлүүдийг нэрлэнэ үү.



Барилдаан

Зүлэг ногоон дэвжээнээ
 Зүүн, баруунаас дэвсээр гарч ирсэн
 Бяцхан бөхчүүд дундаас
 Бадрал найзыгаа олж харлаа.
 Урдаас нь өрөөд зогсож байгаа
 Учраа бөх нь
 Уржигдар Бадралд тусалсан
 Улмаа гэдэг жаал байлаа.
 Хүч бяраараа Бадрал
 Хавьгүй илүү байсан ч
 Арга мэхээрээ Бадрал
 Аргагүй сайн хэдий ч
 Өөрөө унаж байснаа санаад
 Өргөөд зөөлөн унагалаа.
 Өвдөг шороодсон Улмаа
 Өөдөөс нь инээсээр тахимаа өглөө.
 Харин Бадрал тугаа тойрохоор
 Хүчит жигүүртэн адил дэвсээр гүйлээ.



Шүлэгт монгол бөхийн дэг ёсны талаар өгүүлсэн хэсгийг олоорой.



Асуултын дагуу ярилцаарай.

- Хэн давсан бэ? Бадрал уу? Улмаа юу?
- Бадрал Улмааг яагаад зөөлөн унагасан бэ?



Бөхийн барилдааны дарааллыг зөв тохируулж дугаарлая.



Монгол бөхийн барилдааны дэг ёсноос

Монгол бөхийн барилдаан бол монгол наадмын хамгийн чухал төрөл юм. Барилдах бөхчүүд зүүн, баруун жигүүрээс гарч ирнэ. Барилдааны талбайн зүүн талын магнайд хамгийн том цолтой бөх, баруун талын магнайд түүний удаах цолтой бөх гэх мэтээр цолны дэс дарааллаар, ам угтуул бөхчүүдийн хамт дэвэн дэвсээр төв асрын өмнөх тугийн өмнө хэдэнтээ шавна.

Барилдаад давсан бөх тахимаа авсны дараа засуул малгайг нь өмсгөмөгц дэвэн дэвсээр наадмын төв асрын өмнөх тугийг тойрон наадамчин олноо баясгадаг.

Унасан бөх элэг бүсээ тайлан тахимаа өгдөг нь унаснаа хүлээн зөвшөөрсний илэрхийлэл юм.



Асуултын дагуу ярилцаарай.

- Барилдааны талбайд бөхчүүд ямар дарааллаар гардаг вэ?
- Тахимаа өгөх нь ямар утгатай вэ?
- Давсан бөх ямар ёс үйлддэг вэ?



Багт хуваагдан сонирхсон сэдвээ сонгон, мэдээлэл цуглуулж, боловсруулан, ангийнхандаа танилцуулаарай.

Бөхийн өмсгөл

Засуулуудын ёс

Бөхийн бэлтгэл

Бөхийн цол

Бөхийн мэх


Барилдааны журам

Алдартай бөхчүүд

8. ААВЫН ЗАХИАС



1996 оны Улсын их баяр наадмын өмнө дархан аварга Б.Бат-Эрдэнийн хөл гэмтэж, барилдахад хэцүү байсан ч найз нөхдийн зөвлөснөөр барилдсан гэдэг. Тэрээр улсын наадамд найман удаа түрүүлээд байжээ.



Наадмын өглөө Бат-Эрдэнэ аварга гэмтсэн хөлдөө савх мод чиг барьж боон, монгол гутлаа өмсөөд барилдахаар гарчээ.

Монгол бөхийн тэсвэр хатуужлыг харуулан барилдаж давсаар арслан Д.Мөнх-Эрдэнэтэй үзүүр түрүүнд үлджээ. Тэд дөрвөн цаг орчим барилдсаны эцэст Бат-Эрдэнэ аварга давж, улсын наадамд ес дэх түрүүгээ авчээ.

Хожим Д.Мөнх-Эрдэнэ арслан:

- Тухайн үед Бат-Эрдэнэ аваргын хөл бэртэж, бүрэн эдгэрээгүй байсныг мэдсэн боловч наадмын өглөө аав маань “Монгол хүн байна даа. Аваргын бэртэлтэй хөлтэй нь битгий барилдаарай” гэсэн сэн. Тэр жил аавынхаа захиасыг биелүүлсэн наадам болсон доо хэмээн дурсжээ.



Асуултын дагуу ярилцаарай.

Мөнх-Эрдэнэ арслан аавынхаа захиасыг биелүүлсэн үү?



Дээрх эхэд монгол бөхийн ямар зан чанарын тухай өгүүлсэн байна вэ?

9. БӨХИЙН ЦОЛ



Улсын их баяр наадамд тав давсан бөхөд **начин** цол, зургаа давбал **харцага**, долоо давбал **заан**, найм давбал **гарьд**, ес давбал **арслан**, түрүүлбэл **аварга** цол олгодог. Тиймээс бөхийн цол нь амжилтынх нь илрэл болдог.



Монголчууд хүчит бөхчүүдээ яагаад ингэж цоллодог юм бол?



Дээрх эхэд өгүүлснээр хэд давсан бөхөд ямар цол олгодгийг тогтоож аваарай.



Дээрх эхийг харалгүйгээр харгалзуулан тэмдэглэж, өөрийгөө сориорой.



Зөв хариултыг дугуйлаарай. (2 хариулт нь зөв)

- Бөхчүүд барилдах бөхөө өөрсдөө сонгодог.
- Монгол бөхчүүд барилдахдаа жин, насны ялгаа харгалздаггүй.
- Бөхчүүд тодорхой хүрээнээс гарахгүйгээр барилдах ёстой.
- Барилдах бөхчүүдийг хоёр хоёроор нь ээлжлэн талбайд гаргадаг.
- Бөхийн тохой, өвдөг, толгой газар хүрвэл унасанд тооцдог.



Бөх хүнд байх ёстой зан чанаруудаас нэрлэж бичнэ үү.

.....

.....

СУРАЛЦСАНАА ДҮГНЭН ЦЭГНЭ



1. Дараах дүгнэлтүүдийг анхааралтай уншаад, мэддэг, чаддаг болсноо цэнхэр; өөрт хэвшүүлснээ ногоон; хараахан хэвшүүлээгүйгээ улаан энгийн харандаагаар ялгаж будаарай.
2. Улаанаар будсан хэсэгт дүгнэлт хийж, өөртөө хэвшүүлэхийг зориорой.

I бүлэг. Биеэ таньж, билиг авьяасаа хөгжүүлье

Би зөв мэндлэхээс сайн харилцаа эхэлдгийг ойлгосон. Тиймээс хүн бүртэй зүй зохистой мэндэлдэг болсон.

Эрдэм номыг эрт сурах тусмаа сайн. Амжилттай сурахын тулд зорилго, ажлын төлөвлөгөөтэй байх хэрэгтэйг ойлгож, ажлаа цаг тухайд нь хийдэг болсон.

Асуудал гэдэг хэцүү зүйл биш. Асуудал юунаас үүссэнийг эргэцүүлэн, зөв олж харж, асуудлыг эхлээд өөрөөсөө эрэх ёстойг би ойлгосон.

Зөв шийдэл гаргахын тулд түүнээс үүдэх үр дагаврыг боддог болсон. Багш, аав, ээжээсээ асууж, оновчтой шийдлийг хамтран гаргадаг болсон.

II бүлэг. Ачлах ариун ёс, хүндлэх хүний ёс

Төрүүлж, өсгөсөн аав, ээжийнхээ ачийг би ухаарсан. Тэднийхээ ачийг хариулж барахгүй ч, сайн сурч баярлуулахыг хичээдэг болсон.

Нас маань бага гэлгүй нутаг усныхнаа баярлуулж, бахархуулж болохыг Монголын алдарт хүмүүс, тусч, өгөөмөр охины үлгэр дуурайллаас ойлгож авлаа.

Аав, ээжийнхээ ачид үг, үйлдэл, сэтгэлээрээ хэрхэн талархахыг мэдэж, хэрэгжүүлэхийг хичээх боллоо.

Эвтэй бол ямар ч бэрхшээлийг хамтдаа даван туулах хүчтэйн жишээг Эзэн Чингисийн үйлээс ойлгож, эв нэгдэл эелдэг зангаас эхэлдгийг мэдэж авлаа.

Сайн найзынхаа алдааг салхинд хийсэх мэт мартаж, сэтгэлээр хүргэсэн тусыг нь хаданд сийлсэн мэт марталгүй санаж явах ёстойг ойлголоо.

Уучлал сэтгэлээс төрж, үйлдлээр илэрдгийг ойлголоо. Уучилсан хүн уужирч, уучлуулсан нэг нь ухаардаг шидтэй юм байна.

Хүсэл, шуналаа ялгаж сурлаа.
Шунах, атаархах сэтгэлийг
хорьж, тэвчиж сурах нь сайн
үйл гэдгийг мэдлээ.

Томчуудын үг, сургаалыг эргэцүүлж,
зөв, бурууг ялгах хэрэгтэйг
ойлголоо. Буруу үйлдлийг даган
биелүүлэхгүй байх, буруу гэдгийг нь
хэлэх зоригтой боллоо.

Нинжин сэтгэлийн хүчээр юуг ч
давж болдгийг цасан шуурганаас
амьд гарч, хүүхдийн амь аварсан
ахын жишээнээс ойлголоо.

Өрөвч, нинжин сэтгэлээр
бусдыг энэрч, туслах нь өөрт
болон бусдад маш их аз жаргал
бэлэглэдгийг ухаарлаа.

Зөв, эерэг бодлоос сайн сайхан
бий болдог, буруу, сөрөг бодлоос
муу муухай гардгийг ойлгож,
бодлоо цэгнэж, эерэг болгож
сурлаа.

Бусдыг баярлуулахын тулд би
эхлээд ажиглаж, юу хэрэгтэй
байж болохыг нь мэдэж, түүнийг
нь өөрийн чадах чинээгээр хийж
өгдөг болсон.

III бүлэг. Уламжлалт аж төрөх ёс, зан үйл

Монгол үндэсний дээл,
хувцас бол ур ухаан, учир
утга шингэсэн хувцас гэдгийг
ойлгож, бахархал, хүндэтгэлтэй
өмсдөг боллоо.

Цагаан сарын идээ гэдэг цаанаа
нарийн учир утгатай, ухаарч
ойлгох ёс жаягтайг мэдэж авлаа.
Хэн, хэдэн давхар идээ засахыг
мэдэж авлаа.

Айраг, тараг, ааруулын ач
тус, хийх арга, хадгалах
сав гээд энгийн боловч
мэддэггүй байсан олон
зүйлийг ойлгож авлаа. Одоо
би чихэрлэг ундаа биш,
сүү тараг уухыг эрхэмлэх
болсон.

Монгол үхрийн ямар ямар төрөл
байдгийг, хэдэн настай үхрийг юу гэж
нэрлэдгийг, ямар ашиг шимтэйг, ямар
зүстэй, юу гэж дууддагийг гээд олон
зүйлийг мэдлээ.

Зөвхөн монгол бөх, бөхийн барилдааны
олон онцлогийг мэдэж авлаа. Монгол
бөхчүүд хүчтэй, ухаантай, тэсвэр тэвчээртэй,
зөөлөн сэтгэлтэй гэдгийг ойлголоо.